

**МОНГОЛ УЛС
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**



**“ХАДНЫ ЗУРГИЙН ШИНЭ СУДАЛГАА
(ЧУЛУУН ЗЭВСГИЙН СҮҮЛЭЭС ХҮРЛИЙН ЭХЭН ҮЕ)”
СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР
2023**

Улсын бүртгэлийн
дугаар

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШyCc-2019/63

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

**“ХАДНЫ ЗУРГИЙН ШИНЭ СУДАЛГАА
(ЧУЛУУН ЗЭВСГИЙН СҮҮЛЭЭС ХҮРЛИЙН ЭХЭН ҮЕ)”**

Суурь судалгааны төслийн тайлан
2019-2022

Төслийн гүйцэтгэгч байгууллага:	Археологийн хүрээлэн
Төслийн удирдагч:	Н.Батболд, доктор (Ph.D), Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын эрхлэгч Гарын үсэг
Санхүүжүүлэгч байгууллага:	Шинжлэх ухаан, технологийн сан
Захиалагч байгууллага:	Боловсрол, Шинжлэх ухааны яам
Тайлан өмчлөгч байгууллага:	ШУА-ийн Археологийн хүрээлэн, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

**УЛААНБААТАР
2023**

ТӨСЛИЙН УДИРДАГЧ

НАЦАГИЙН БАТБОЛД

Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын эрхлэгч, доктор (Ph.D)
Гарын үсэг

.....
2022 оны 12-р сарын 28-ны өдөр

ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧИД:

ЦАГААНЫ ТӨРБАТ

МУИС-ийн Археологийн судалгааны төвийн захирал, доктор (Ph.D), профессор
Гарын үсэг

.....
2022 оны 12-р сарын 28-ны өдөр

ЖАМЪЯН-ОМБЫН ГАНТУЛГА

Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын ЭША, доктор (Ph.D)
Гарын үсэг

.....
2022 оны 12-р сарын 28-ны өдөр

ДУНБҮРЭЭГИЙН БАТСҮХ

Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын ЭША, магистр
Гарын үсэг

.....
2022 оны 12-р сарын 28-ны өдөр

ГАНБААТАРЫН ГАЛДАН

Археологийн хүрээлэнгийн Хүннү ба эртний улсуудын судалгааны салбарын ЭША, магистр
Гарын үсэг

.....
2022 оны 12-р сарын 28-ны өдөр

ДАМЧААБАДГАРЫН СОДНОМЖАМЦ

Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын ЭША, магистр
Гарын үсэг

.....
2022 оны 12-р сарын 28-ны өдөр

ЦОГТБАЯРЫН ЦЭЛХАГАРАВ

Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын ЭША, магистр
Гарын үсэг

.....
2022 оны 12-р сарын 28-ны өдөр

ГАРЧИГ

РЕФЕРАТ	5
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
1. Ажлын зорилго	8
2. Зохион байгуулалтын талаар	10
3. Судалгааны ажлын судлагдсан байдал, шинэлэг тал	11
4. Гүйцэтгэсэн үе шат	13
5. Сэдэвт ажлын гүйцэтгэл	18
5.1. Хээрийн судалгааны ажил	18
5.2. Эрдэм шинжилгээний хурал	34
6. Бүтээлийн тодорхойлолт	36
7. Суурь судалгааны төслийн үр дүн	38
8. Хавсралт	40
- Эрдэм шинжилгээний өгүүллүүд	
- Эрдэм шинжилгээний илтгэлүүд	
- Хээрийн судалгааны ажлын тайлангууд	

РЕФЕРАТ

“Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” төслийн хүрээнд чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үед холбогдох хадны зургийн бүртгэл баримтжуулалтыг өнөөгийн шаардлагын түвшинд нийцүүлэн хийж тухайн он цагт хамаарах хадны зургийн томоохон хэмжээний мэдээллийн сан бий болгох, тэдгээрийг археологийн биет олдворуудтай харьцуулан судлах, Монголын болон гадаадын судлаачдын судалгааны хэрэглэгдэхүүн, дүгнэлтийг нэгтгэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах, хадны зураг судлалаар ажилладаг гадаадын судлаачидтай холбоо тогтоож хамтран ажиллах, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, Монголын чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үеийн хадны зургийн дурсгалын талаар олон улсын болон дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх өгүүллүүд болон нэгэн сэдэвт зохиол бичиж хэвлүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэх зорилт тавин ажиллалаа.

Бидний энэхүү төсөл нь бүхэлдээ шинэлэг байсан бөгөөд түүнийг бид доорх байдлаар тодорхойлж ажлаа эхлүүлсэн билээ. Үүнд, нэгдүгээрт, Монголын археологийн судалгаанд өмнө нь Хадны зургийн дурсгалыг он цагийн хувьд чулуун зэвсгийн үе, хүрлийн үе, төмрийн түрүү үе, эртний улсуудын үе хэмээн ерөнхий он цагийн хүрээнд авч үзэж нэг цаг үед холбогдох дурсгалуудыг тусгайлан судлах ажил хийгдэж байсангүй. Гадаад дотоодын археологийн төслүүд зөвхөн өөрсдийн судалгаа хийж байсан тухайлсан бүс нутагт байгаа хадны зургийг нийтэд нь хэвлэн нийтэлж судалгааны эргэлтэд оруулдаг байв. Хоёрдугаарт, Хүрлийн үе буюу НТӨ III-I мянган, өөрөөр хэлбэл 2000 орчим жилийн хугацааг хамарч буй энэ түүхэн үеийн түрүү үе, хөгжингүй үе, хожуу үе зэрэг бүх үе шатанд холбогдох археологийн соёлуудыг нээн илрүүлээд байгаа юм. Иймээс хүрлийн үеийн хадны зургийн ангиллыг илүү нарийсган үе шат болгонд хамаарах зургуудыг ангилах боломж бүрдэж байна хэмээн үзсэн билээ.

Төслийн эрдэм шинжилгээний судалгаа:

1-рт Говийн бүсийн хадны зургийн судалгаа

2-рт Баруун бүсийн хадны зургийн судалгаа

3-рт Төвийн бүсийн хадны зургийн судалгаа гэсэн гурван чиглэлд хийгдсэн.

Говийн бүс нутаг буюу Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт хадны зургийн хайгуул судалгаа хийж чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үед холбогдох хүний нүүрний хэлбэр төрх бүхий хадны зургийн дурсгалт газруудыг бүртгэн баримтжуулж энэ төрлийн өвөрмөц дүрслэлтэй дурсгалуудын тархалт, хамрах хүрээг тогтоож чадсан юм. Ялангуяа Өмнөговь, Дорноговь аймгийн нутаг Монгол Улсын хилийн бүс дагуу суурь судалгааны ажилд хамаарах зургуудыг шинээр нээн илрүүлсэн нь чухал ач холбогдолтой ажил болсон юм.

Баруун бүс нутаг буюу Баян-Өлгий аймгийн нутагт ОХУ, Германы судлаачидтай хамтарсан судалгаа хийж чулуун зэвсгийн сүүл үеийн хадны зургийн үе давхаргыг тодруулах судалгаа хийсний зэрэгцээ хүрлийн эхэн үе буюу Хэмцэгийн соёлд холбогдох хадны зургийн давхаргыг бүртгэн баримтжуулж үр дүнг нь хэвлэн нийтлээд байна.

Төвийн бүс нутаг буюу Архангай аймгийн Тариат сумын нутаг Чулуут, Суман голын савд хадны зургийн хайгуул судалгаа хийж хүрлийн эхэн үед холбогдох хадны зургийн дурсгалуудыг баримтжуулан бүртгэсний зэрэгцээ энэ бүс нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн суурьшин амьдарч байсан ул мөрийг илрүүлэх, түүнчлэн хадны зургийг цохиж сийлэх явцад хагарч бутарч үлдсэн чулуун багаж зэвсгийн үлдэгдлийг хайх зорилгоор Аваргын буланд орших хадны зурагтай нэгэн хавтан чулууны өмнө талд бага хэмжээний газарт сорилтын малтлага хийж шавар савны хагархай, чулуун зэвсгийн зүйлс илэрч олдсон нь хадны зургийн он цагийг нарийвчлан сэргээн тодруулах боломж бүрдэж байна.

Хүснэгт 1: Төслийн хүрээнд хийгдсэн ажлын жагсаалт

<i>(Үр дүнгийн даалгавар, ажлын програмын дагуу) Хийгдэх ажил (үр дүнгийн даалгавар)</i>	<i>Хийгдэх ажил (ажлын програм)</i>	<i>Хийгдсэн байдал</i>
Хээрийн судалгаа	Хээрийн судалгаа	4 удаагийн судалгаа бүрэн хийгдэж, тайлан бичигдсэн.
Эрдэм шинжилгээний хурал	Эрдэм шинжилгээний хурал	“Төв Азийн эртний нүүдэлчдийн хадны зураг” хурлыг зохион байгуулж, эмхтгэл хэвлүүлсэн
Эрдэм шинжилгээний өгүүлэл - 6	Эрдэм шинжилгээний өгүүлэл - 7	Хэвлэгдсэн
Эрдэм шинжилгээний илтгэл - 6	Эрдэм шинжилгээний илтгэл - 7	Хэвлэгдсэн
“Чулуут-Суман голын хадны зураг” нэгэн сэдэвт бүтээл	“Чулуут-Суман голын хадны зураг” нэгэн сэдэвт бүтээл	Н.Батболд, Д.Содномжамц нар бүтээлийг бичиж бэлэн болгов.
“Монголын хадны зургийн нууцад нэвтэрхүй” нэгэн сэдэвт бүтээл	“Монголын хадны зургийн нууцаас” нэгэн сэдэвт бүтээл	Н.Батболд, Г.Галдан нар бичиж хэвлүүлсэн

Энэхүү төслийн зорилтыг хэрэгжүүлэхэд төслийн удирдагчаар ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Н.Батболд, оролцогчоор эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор Ц.Төрбат, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Д.Батсүх, Ц.Цэлхагарав, Г.Галдан, Д.Содномжамц туслах ажилтан МУБИС-ийн оюутан Ж.Одсүрэн, Г.Тогтохбаяр, Б.Жавзансүрэн, Ё.Ойдов, УБ-ын ИС-ийн төгсөгч Б.Лхагвасүрэн, жолооч Ц.Ганзориг, Ч.Ганхүү нарын бүрэлдэхүүнтэй баг амжилттай ажиллалаа.

Түлхүүр үг

Хадны зураг, чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үе, хадны зургийн тархалт, эрдэм шинжилгээний тайлан, эрдэм шинжилгээний хурал, бүтэц, арга зүй, нэгэн сэдэвт бүтээл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	<i>Төслийн хүрээнд хийгдсэн ажлын жагсаалт</i>	6
Хүснэгт 2	<i>Төслөөр гүйцэтгэсэн ажлын үе шат</i>	14
Хүснэгт 3.	<i>Хүний нүүрний дүрс бүхий хадны зургийн дурсгалт газрууд . . .</i>	19
Хүснэгт 4.	<i>Судалгаанд хамрагдсан хадны зургийн дурсгалууд</i>	24
Хүснэгт 5.	<i>Хайгуулаар бүртгэсэн дурсгалууд</i>	27
Хүснэгт 6.	<i>Чулуут болон Суман голын хадны зургийн дурсгалт газрууд..</i>	30
Хүснэгт 7.	<i>Суурь судалгааны ажлын хүрээнд төлөвлөсөн болон гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл, илтгэлийн үзүүлэлт</i>	36

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	<i>Судалгаа хийсэн дурсгалт газруудын байршил</i>	22
Зураг 2.	<i>Цагаан дэрсний Бичигтийн усны хадны зургийн дурсгалт газрын ерөнхий байдал</i>	22
Зураг 3.	<i>Цагаан дэрсний Бичигтийн усны хадны зургийн хэсгээс</i>	22
Зураг 4.	<i>Худгийн бичээсийн хадны зургийн хэсгээс</i>	22
Зураг 5.	<i>Цагаан дэрсний Бичигтийн усны хадны зургийн хэсгээс</i>	22
Зураг 6.	<i>Газрын зураг. Судалгаанд хамрагдсан дурсгалт газрууд . . .</i>	23
Зураг 7.	<i>Газрын зураг. Бударын чулууны дурсгалт газарт буй археологийн дурсгалууд</i>	26
Зураг 8.	<i>Шинээр илрүүлсэн хадны зосон зургууд</i>	27
Зураг 9.	<i>Хадны зургийн дурсгалт газруудын байршил</i>	31
Зураг 10.	<i>Малтлага болон хайгуул судалгаа хийсэн дурсгалт газрын байршил</i>	32
Зураг 11.	<i>Чулуут голын Аваргын булан</i>	34
Зураг 12.	<i>Хурлын явц</i>	35
Зураг 13.	<i>Хурлын явцаас</i>	35

НЭГ. АЖЛЫН ЗОРИЛГО

Монгол орон хадны зургийн дурсгалаар маш баялаг орон бөгөөд хадны зураг нь он цагийн хувьд чулуун зэвсгийн үеэс дундад зууны үеийг хамарсан дурсгал юм. Гэвч хадны зургийн судалгааны өнөөгийн түвшинд он цагийн хамаарлыг тодорхой үеүдэд нарийн ангилан судалж хараахан чадаагүй байгаа бөгөөд ихэвчлэн ерөнхий байдлаар он цагийг тогтоон авч үзэж байгаа билээ. Монголын хадны зургийн археологийн үечлэлийг нэгбүрчлэн орчин үеийн шинжлэх ухааны онол аргагүйн түвшинд дэлгэрэнгүй тодорхойлж, тэдгээрийн харилцан холбоо, үе үеийн онцлогийг бүрэн тодруулж чадаагүй байгаа нь хадны зургийн судалгааны нэгэн чухал тулгамдсан асуудал хэвээр байна. Өнөөгийн судалгааны байдлаас харахад Монголын хадны зургийн дийлэнх хувь нь хүрэл ба түрүү төмрийн үед хамаардаг, харин түүнээс өмнөх буюу чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үед холбогдох зураг маш ховорхон байдаг. Энэ нь Монгол орны нутагт хадны зургийн хайгуул судалгаа системтэй хийгдээгүй, зөвхөн археологийн хавсрага судалгаа шинжтэй явж ирснээс үүдэлтэй бөгөөд илэрсэн дурсгалт газруудын бүртгэл баримтжуулалт хангалтгүй, мэдээллийн сан байхгүйтэй холбоотой юм. Иймээс бид энэхүү суурь судалгааны төслийн хүрээнд Монгол орны хадны зургийн судалгаанд цагаан толбо болж буй чулуун зэвсгийн сүүл үеэс хүрлийн эхэн үед холбогдох хадны зургийг бүртгэн баримтжуулж судалгааны эргэлтэнд оруулах зорилго тавьж байна.

Чулуун зэвсгийн үеийн сүүл үеэс уур амьсгал хуурайшиж өнөөгийн хэв шинжийг олж эхэлсэн байгаль, цаг агаарын хувьсал өөрчлөлт нь Монгол орны нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөх үндэс болсон бөгөөд чулуун зэвсгийн төгсгөл үеэс үйлдвэрлэх аж ахуй буюу мал аж ахуйн эхлэл тавигдсан ажээ¹. Эртний хүмүүс байгалийн цэвэр зэсийг ашиглан гоёл чимэглэл, хөдөлмөрийн багаж зэвсэг хийж урьдын уламжлалт чулуун зэвсгийн хамт хэрэглэж байсан зурвас үеийг хүн төрөлхтөний түүхэнд энеолит буюу зэс чулууны үе гэж нэрлэдэг бөгөөд энэ үеийг Монголын эртний оршин суугчид дамжиж ирсэн байна. Энэ үе нь чулуун зэвсгээс хүрэл зэвсгийн үед шилжих шилжилтийн завсрын богино үе байсан юм.

Судлаачдын үзэж буйгаар хүн төрөлхтөний туулан өнгөрүүлсэн чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн хүртэлх үе нь нэн эртний урлаг, оюун сэтгэлгээний хэв маяг эрхэлж байсан аж ахуйн өөрчлөлттэй холбоотойгоор өөрчлөгдөж эхэлсэн үе буюу эртний нүүдэлчдийн аж ахуй, урлаг соёлын үндэс суурь үүсэн хөгжиж эхэлсэн үе юм. Гэвч энэ үеийн археологийн судалгаа бараг хийгдээгүй байгаа хэмээн үзэж болох тул чулуун зэвсгээс төмөрлөг зэвсэгт шилжсэн шилжилтийн энэ үеийн нийгэм соёлын хувьсал, хөгжлийн талаар тодорхой ойлголт, мэдлэгийг олж авахад хадны зургийн дурсгал судалгааны тулгуур хэрэглэгдэхүүн болно.

Судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд Монгол орны нутагт 500 гаруй хадны зургийн дурсгалт газар бүртгэгдээд байгаа боловч судалгаанд хамрагдан эрдэм шинжилгээний эргэлтэнд орсон нь цөөн юм. Эдгээрийн ихэнх нь урьдчилсан байдлаар бага судлагдсан, зарим нь судлаачдын зам зуур тааралдсан хадны зургийн дурсгалт газруудын зургаас сонирхолтой хэмээн үзэж зарим нэгийг

¹ Д.Одсүрэн. Арц Богдын нуруу орчмын шинэ чулуун зэвсгийн дурсгалууд. //Түүхийн ухааны доктор (Ph)-ын зэрэг горилсон бүтээл. УБ., 2018, тал 130.

мэдээлсэн аман мэдээ төдийхнөөр хязгаарлагдаж байна. Мөн хадны зургийн ихэнх дурсгалт газруудын баримтжуулалт нэн ядмаг, гэрэл зураг байхгүй, гар зураг төдий байхаас гадна газар зүйн байрлал нь бүрхэг байгаа нь судалгаанд ихээхэн хүндрэл үүсгэж байна.

Хэдий тийм боловч Монголын асар баялаг хадны зургийн ертөнцөд чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үед холбогдох зургууд цөөн тоотой илэрч мэдэгджээ. Тухайлбал, Архангай аймгийн Тариат, Жаргалант, Цэцэрлэг сумын нутаг Чулуут голын хадны зураг, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант хайрхан, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг Жаргалантын адгийн ширээ зэрэг газруудыг нэрлэж болно. Мөн түүнчлэн энэ үед холбогдож болох хадны зургийн дурсгалууд Өмнөговь, Дорноговь зэрэг говийн бүсийн аймгуудын нутагт байгаа мэдээ бий.

Монгол орны төв нутаг буюу Архангай аймгийн нутаг Чулуут голын хөндийд өмнө нь хийсэн судалгааны ажлууд байгаа боловч ихэнх дурсгалуудын тухайн үеийн судалгааны үеийн болон одоо байгаа газрын нэр зөрөөтэй, хэвлэгдсэн дурсгалуудын гэрэл зураг бараг байхгүй, гар зургуудыг яаж цаасан дээр буулгаж хэвлэсэн нь тодорхойгүй, тоо хэмжээний хувьд зөрөөтэй зэрэг байдлууд нь бүс нутгийн болон Монгол орны хадны зургийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэхэд ихээхэн хүндрэл үүсгэж байна. Иймээс тухайн бүс нутгийн неолит, энеолитийн үед холбогдох хадны зургийн дурсгалыг дахин нягтлан судалж тоо хэмжээг нарийвчлан тогтоох, байршлыг тодорхой тэмдэглэсэн газрын зураг үйлдэх, он цагийн харьцуулсан судалгаа хийх, тухайн бүс нутгийн хадны зураг эртний нүүдэлчдийн урлагийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг зэргийг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Бид Монголын чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үед холбогдох хадны зургаар дамжуулан тухайн үеийн урлагийн түүхийг судлахад дан ганц хадны зургийн судалгаа хангалтгүй хэмээн үзсэний үндсэн дээр дурсгалт газрын дэргэд буй булш оршуулгын дурсгалыг малтан судалж илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнийг харьцуулан нарийвчлан судлах, он цагийг байгалийн шинжлэх ухааны судалгааны үр дүнд тулгуурлан тогтоох шаардлагатай хэмээн үзэж байна. Ингэснээр хадны зураг, булш оршуулгын дурсгалын харилцан хамаарал, тухайн дурсгалыг үлдээгчдийн оюуны сэтгэлгээ, шүтлэг бишрэлийн асуудлыг хөндөн тавих боломжтой болох юм.

Мөн түүнчлэн Монголын эртний нүүдэлчдийн урлагийн түүхийн төдий л сайн судлагдаагүй бүрхэг хэсэг болох чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үед холбогдож болох хадны зургийн дурсгалууд говийн бүс нутагт буй тухай мэдээллийг шалгаж, хадны зургийн дурсгалт газрын бүртгэл баримтжуулалтыг өнөөгийн шаардлагын түвшинд нийцүүлэн хийж судалгааны эргэлтэнд оруулах шаардлагатай байна.

Ер нь Монголын эртний нүүдэлчдийн урлагийг тусгайлан судласан зүйл өнөө хэр хангалттай биш бөгөөд хадны зургийн дурсгалыг олон талаас нь цогцоор судалсан зүйл үгүй байна. Мөн нөгөө талаас өнөө үед ялангуяа говийн бүс нутагт ихээр хөгжиж буй дэд бүтэц, уул уурхай, ашигт малтмал ашиглахтай холбоотой үйл явц болон байгаль экологийн тэнцвэрт бус байдал, хувь хүний санаатай болон санамсаргүй үйл ажиллагааны явцад хадны зургийн дурсгалыг гэмтэж сүйдэхээс нь өмнө амжиж судлан баримтжуулах шаардлага зүй ёсоор урган гарч байгаа юм.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Энэхүү төслийн удирдагчаар ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Н.Батболд, оролцогчоор эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор Ц.Төрбат, эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ж.Гантулга, магистр Д.Батсүх, Ц.Цэлхагарав, Г.Галдан, Д.Содномжамц нар тус тус ажилласан болно.

Төслийн удирдагч

Доктор *Нацагийн Батболд*. 2000 онд УБ-ын ИС-ийн Түүхийн ангийг археологич мэргэжлээр төгссөн. 2011 онд “Монголын хадны зургийн судалгаа (Говийн бүсийн хэрэглэгдэхүүнээр)” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Тэрээр Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн удирдагчаар ажиллаж байна. Одоо тус хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын эрхлэгч, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар ажилладаг.

Үндсэн оролцогч

Доктор, профессор *Цагааны Төрбат*. 1995 онд МУИС-ийг төгссөн. 2004 онд “Хүннүгийн жирийн иргэдийн оршуулгын зан үйл” сэдвээр боловсролын докторын зэрэг хамгаалсан байна. Тэрээр Монгол-Францын хамтарсан “Монгол Алтайн түрүү түүхийн үе” төслийн удирдагчаар ажиллаж байна. Одоо МУИС-ийн Археологийн судалгааны төвийн захирлаар ажиллаж байна.

Доктор *Жамъян-Омбын Гантулга*. 2001 онд МУБИС-ийг төгссөн. Монголын хүрлийн үеийн археологийн судалгааны асуудлаар Францын Бургундын их сургуульд докторын зэрэг хамгаалсан. Тэрээр Монгол-Монакогийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төслийн удирдагчаар ажилладаг. Газарзүйн мэдээллийн сан (GIS)-г археологийн судалгаанд ашиглах талаар дагнан ажиллаж байгаа судлаачдын нэг юм.

Магистр *Дунбүрээгийн Батсүх*. 1996 онд МУИС-ийг төгссөн. “Дундговь аймгийн нутгаас шинээр олдсон хүрэл олдворууд” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан. Одоо төмөр зэвсгийн үеийн Пазырыкийн соёлын булшны судалгааны чиглэлээр докторын ажил бичиж байгаа.

Магистр *Дамчаабадгарын Содномжамц*. 2012 онд МУИС-ийг төгссөн. 2017 онд БНХАУ-ын Жилиний ИС-д “Уйгурын барилгын дээврийн чимэглэл” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан. Одоо тус хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтнаар ажилладаг.

Магистр *Цогтбаярын Цэлхагарав*. 2014 онд МУИС-ийг төгссөн. 2018 онд МУБИС-ийн Түүхийн тэнхимд “Монгол нутаг дахь хиргисүүрийн тархалт ба оршуулгын зан үйлийн асуудалд” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан. Одоо тус хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтнаар ажилладаг.

Магистр *Ганбаатарын Галдан*. 2007 онд МУИС-ийг төгссөн. 2010 онд “Бага газрын чулууны хадны зургийн судалгаа” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан. Одоо тус хүрээлэнгийн Хүннү ба эртний улсуудын судалгааны салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтнаар ажилладаг.

ГУРАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН СУДЛАГДСАН БАЙДАЛ, ШИНЭЛЭГ ТАЛ.

Одоогоор чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үеийн хадны зургууд Архангай, Баян-Өлгий, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгийн нутгаас цөөн тоотойгоор илэрч мэдэгдээд байна. Тухайлбал, Архангай аймгийн Тариат сумын Чулуут гол, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант хайрхан², Зүүн хацавч, Далайн дуулга³, Номгон сумын Хахуулын гол⁴, Долоон уул⁵, Уртын гол⁶, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Жаргалантын адгийн ширээ⁷, Төв аймгийн Лүн сумын Элстэйн даваа⁸ зэрэг газруудыг нэрлэж болно. Эдгээрээс Чулуут гол, Жавхлант хайрхан, Жаргалантын адгийн ширээ зэрэг газруудад судалгааны ажил хийгдсэн ба бусад газруудын хадны зургууд мэдээ төдий зөвхөн гэрэл зургийг л хэвлүүлсэн байдаг байна.

Чулуутын голын хадны зургийг 1977 онд Зөвлөлтийн геологчид анх удаа шинжлэх ухаанд мэдээлжээ. Энэ үеэс эхлэн 1980-аад оны сүүлч хүртэл Зөвлөлтийн археологчид А.П.Окладников, Э.А.Новгородова, Монголын археологич Т.Санжмятав нар бие биеэсээ хамааралгүй судалсан байна. Дээрх гурван судлаач тус бүрдээ судалгааны үр дүнгээ хэвлүүлсэн байна. А.П.Окладников 1981 онд “Чулуутын голын хадны зураг”⁹ нэгэн сэдэвт зохиол хэвлүүлсэн бол Т.Санжмятав 1995 онд хэвлүүлсэн “Монголын хадны зураг”¹⁰ номондоо Чулуутын голын зургуудыг өргөн ашиглажээ. Харин Э.А.Новгородова 1984 оны “Монголын хадны зургийн ертөнц”¹¹ номондоо болон 1989 оны “Эртний Монгол орон”¹² номондоо Чулуутын голын хадны зургийг нэлээд дэлгэрэнгүй ашигласан төдийгүй тусгайлсан хэд хэдэн өгүүлэл франц, герман хэлээр хэвлүүлсэн байдаг.

Гэхдээ эдгээр зохиол бүтээлүүдэд хэдэн зүйлийн дутагдал байна. Юуны өмнө хадны зургаас зөвхөн чухал гэж үзсэн хэсгээ хэсэгчлэн хуулсан нь бүрэн цогц байдлыг алдагдуулсан байна. Мөн гэрэл зургийн баримтжуулалт байхгүй учир зурагт талбайнуудын дотоод он цагийг ялган харах боломжгүй нэгэн ижил өнгө хэмжээгээр дүрсэлсэн байдаг. А.П.Окладниковын ном тухайн дурсгалын талаар гарсан нэгэн сэдэвт зохиол тул асуудлыг шийдсэн мэт харагдах боловч үнэн хэрэгтээ Чулуут голын хамгийн эртний чухал зургууд огт ороогүй буюу зөвхөн

² Д.Цэвээндорж, Я.Цэрэндагва, Б.Гүнчинсүрэн, Д.Гарамжав. Жавхлант хайрханы хадны зураг. – УБ., 2004.

³ Д.Цэвээндорж, Я.Цэрэндагва, Б.Гүнчинсүрэн. Далайн дуулгын хадны зургийн дүр дүрслэлийн асуудал. – Археологийн судлал. Боть XXIV, Fasc. 4, - УБ., 2007, тал 47-57.

⁴ У.Эрдэнэбат. Хахуулын голын хадны зураг. Археологийн судлал. Боть XXVI, Fasc. 3, - УБ., 2008, тал 32-56.

⁵ Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал. Ред. Л.Дашням, Д.Цэвээндорж. УБ., 1999, тал 37.

⁶ Мөн тэнд, тал 53.

⁷ Ц.Төрбат, Н.Батболд, Д.Батсүх. Жаргалантын Адгийн ширээ, Рашааны тээг ба Чулуут голд хийсэн хадны зургийн судалгаа. – Монголын археологи-2016. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл. – УБ., 2017, т. 243-247.

⁸ Я.Цэрэндагва, Р.Төрбат. Элстэйн давааны зургийн зарим дүрслэлийн тухай. – Нүүдэлчдийн өв соёл, №7, - УБ., 2014, тал 28-29.

⁹ А.П.Окладников. Петроглифы Чулуутын-Гола: Монголия. – Новосибирск, 1981.

¹⁰ Т.Санжмятав. Монголын хадны зураг. – УБ., 1995.

¹¹ Э.А.Новгородова. Мир петроглифов Монголии. – М., 1984.

¹² Э.А.Новгородова. Древняя Монголия (некоторые проблемы хронологии и этнокультурной истории). – М., 1989.

өчүүхэн төлөөлөл нь орсон тул бүрэн гүйцэд гэж үзэх боломжгүй юм. Харин Э.А.Новгородова ба Т.Санжмятав нарын бүтээлүүдэд байгаа нэгэн нийтлэг дутагдал нь дурсгалт газруудын байршил ба харилцан хамаарлыг огт орхигдуулсан байдаг. Иймээс тэдний үзэж баримтжуулсан хадны зурагт газруудыг 100 гаруй км урттай хавцлаас хайж олоод оноох гэдэг нь бараг боломжгүй зорилт болжээ. Мөн тэдний хийсэн гар зургийн хуулбаруудын үнэн бодит байдалд эргэлзэх үндэслэл бий. Тухайлбал Т.Санжмятавын хэвлүүлсэн Хамарын булангийн гэх нэгэн зургийг Э.А.Новгородовагийн хэвлүүлсэн гэрэл зурагтай харьцуулахад нэлээд зөрөөтэй болох нь илт ажиглагддаг.

Чулуут голын хадны зургууд Монголын археологчдын анхаарлын гадна үлдсэнгүй, сүүлийн үед дээрх зургуудыг дахин нээх, эргэж судлах оролдлогуудыг удаа дараа хийжээ. 2011 онд Д.Цэвээндорж, А.Энхтөр, Г.Батболд нар Чулуут голын Тулын булан орчмын газарт ажиллаж олон зуун хадны зургийн гэрэл зургийн баримтжуулалтыг хийсэн бол 2016 онд Н.Батболд, Д.Батсүх нар Аваргын булангаас Хамрын булангийн хооронд мөн олон зуун зургийн гэрэл зургийн баримтжуулалт хийсэн байдаг¹³. Улмаар 2018 оны 3-р сард ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Хүрэл төмрийн судалгааны салбарын судлаачид болон Сэмүүн студийн захирал Б.Баяр нар Суман голын Долгорын булан, Хамрын булан, Чимэдийн тохой, Олгой, Цагаан асгын Бөөн хад зэрэг дурсгалууд, Чулуут голын Ёлтын хясаа, Рашааны хөл, Давхарын булан (Ёлын ам), Ар булан зэрэг дурсгалт газруудад ажиллаж хэдэн зуун зураг чуулбарын гэрэл зургийг авсны дээр урьд өмнө бүртгэгдээгүй олон зургийг анх удаа нээж баримтжуулжээ.

Ерөнхийдөө Чулуут голын хадны зураг харьцангуй судлагдсан мэт харагдах боловч цогцоор нь авч үзсэн системтэй судалгаа хийгдээгүй, тэр дундаа чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үеийн хадны зургийг тодорхойлон ялгаж судалсан зүйл үгүй байна. Дурсгалт газруудын байрлал болон зурагт талбайнууд тодорхой бус байна. Түүнээс гадна өмнөх судлаачдын хэвлүүлсэн гар зурган хуулбаруудын итгэмжтэй байдал эргэлзээ төрүүлж байгаа нь хамгийн ноцтой асуудал болно. Энэ нь цэвэр техникийн шинжтэй алдааны үр дүн байж болох хэдий ч зайлшгүй дээрх зургуудыг дахин олж гэрэл зураг болон видео бичлэгээр баримтжуулж байж цаашид ашиглах бололцоотой болох юм.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг Жаргалантын адгийн ширээгийн хадны зургийг дурсгалыг анх Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд БСШУЯ-ны харьяа Соёлын өвийн төвийн судлаачид 2008 онд илрүүлэн 2011 онд гэрэл зургийг хэвлүүлсэн байна¹⁴. Мөн “Сувдан Сондор” түүх соёлын аяллын үеэр СГЗ Г.Мэнд-Оёо тэргүүтэй судлаачид үзэж олон нийтэд мэдээлсэн байдаг.

“Монголын хүрэл ба түрүү төмрийн үеийн археологийн судалгааны тулгамдсан асуудлууд ба шинэлэг шийдлүүд” суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд 2016 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбарын ажилтнууд уг дурсгалт газарт хадны зургийн

¹³ Ц.Төрбат, Н.Батболд, Д.Батсүх. Жаргалантын Адгийн ширээ, Рашааны тээг ба Чулуут голд хийсэн хадны зургийн судалгаа. – Монголын археологи-2016. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл. – УБ., 2017, т. 243-247.

¹⁴ Г.Энхбат, Б.Даваацэрэн. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Сүхбаатар аймаг. II дэвтр. УБ., 2011, тал 73.

баримтжуулалтыг хийж чулуун зэвсгийн сүүл, хүрэл зэвсгийн эхэн үед холбогдуулж үзжээ¹⁵.

Монголын хадны зургийн судалгааны тулгамдсан асуудлуудын нэг нь уг дурсгалын он цагийг тодорхой тогтоох явдал хэвээр байгаа билээ. Иймээс энэхүү төслийн хүрээнд чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үеийн хадны зургийн дурсгалуудыг бүртгэж баримтжуулах, тухайн үед холбогдох хадны зураг бүхий дурсгалт газрын дэргэд буй булш, оршуулгын байгууламжийг малтан судалж улмаар уг оршуулгын байгууламж болон хадны зураг хоорондын харилцан хамаарлын асуудлыг хөндөн судлахаар төлөвлөсөн. Гэвч дэлхий нийтэд тархсан халдварт өвчний улмаас хөл хорио тогтоож, манай улсын санхүүгийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулж санхүүжилт багассан зэргээс шалтгаалан төлөвлөсөн газраа малтлага судалгаа хийж чадаагүй болно.

2022 онд Архангай аймгийн Тариат сумын нутаг Чулуутын голын савд хадны зурагтай хадны ёроолд сорилтын малтлага хийж үзэхэд ваарны хагархай, чулуун зэвсэг зэрэг эд зүйлс олдсон нь цаашид хадны зургийн дурсгалт газруудад малтлага судалгаа хийж хадны зургийн он цагийн ялгааг нарийвчлан гүнзгийрүүлж судлах, хадны зураг, түүний ойр орчимд буй булш, оршуулгын дурсгалын харилцан хамаарлын асуудлыг хөндөн тавих зэргээр судлаачдын анхаарлыг хандуулах цаг болсныг харуулсан нь тус төслийн шинэлэг тал юм.

“Хадны зургийн шинэ судалгаа (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төслийг хэрэгжүүлснээр Говийн бүс нутаг дахь тухайн үед холбогдох хадны зургийн дурсгалт газруудыг шинээр нээн илрүүлж мэдээллийн сан үүсгээд байна.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭСЭН ҮЕ ШАТ

Энэхүү судалгааны төслийн хүрээнд бид Монгол орны нутагт тархсан хадны зургийн баялаг санд буй чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үеийн хадны зургийн дурсгалуудыг бүртгэн баримтжуулж, Монгол орны эртний оршин суугчдын аж ахуй, урлаг, соёл, шүтлэг бишрэлийн үндсэн болон тулгамдсан асуудлуудыг тодруулан гаргаж, хөгжлийн ерөнхий зүй тогтлыг илрүүлэн, өнөөгийн шинжлэх ухааны түвшинд он цагийг тогтоож, үнэлэлт дүгнэлт өгч, судалгааны хүрээнд түгээх зорилго тавьж ажилласан билээ.

Мөн түүнчлэн чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үед холбогдох хадны зургийн бүртгэл баримтжуулалтыг өнөөгийн шаардлагын түвшинд нийцүүлэн хийж тухайн он цагт хамаарах хадны зургийн томоохон хэмжээний мэдээллийн сан бий болгох, тэдгээрийг археологийн биет олдворуудтай харьцуулан судлах, Монголын болон гадаадын судлаачдын судалгааны хэрэглэгдэхүүн, дүгнэлтийг нэгтгэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах, хадны зураг судлалаар ажилладаг гадаадын судлаачидтай холбоо тогтоож хамтран ажиллах, эрдэм шинжилгээний хурал, зохион байгуулах, Монголын чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үеийн хадны

¹⁵ Ц.Төрбат. Дорнод Монголд нээгдсэн Жаргалантын адгийн хадны зураг. // Орос, Монгол, Хятадын хил залгаа бүс нутгийн эртний нийгмүүдийн соёлын хувсал ба харилцан нөлөөлөл: Төв Ази ба Умард Хятадын хадны зураг – эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017, тал 62-71.

зургийн дурсгалын талаар олон улсын болон дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх өгүүллүүд болон нэгэн сэдэвт зохиол бичиж хэвлүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Энэхүү төслийн хүрээнд Монголын хадны зургийн он цагийн ангиллын үе тус бүрийг нарийвчлан судлах ажлыг эхлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж зохих үр дүнд хүрсэн юм.

Дэлхий даяар үүссэн халдварт өвчний нөхцөл байдлаас шалтгаалан тус суурь судалгааны төсөлт ажлыг 1 жилийн хугацаагаар сунгасны улмаас 2021 оны санхүүжилт дутуу хийгдсэн тул төлөвлөсөн ажлаа гүйцэтгэж чадаагүй болно. Хэдий тийм боловч олгогдсон санхүүжилтын хүрээнд Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Бударын чулуу хэмээх газарт судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Төслийн хүрээнд 3 жилийн хугацаанд хийгдэх ажлын төлөвлөгөөг жил тус бүрээр гаргаж төлөвлөсөн боловч халдварт өвчний хөл хорио, бусад хүчин зүйлээс шалтгаалан 4 жилийн хугацаанд ажлыг зохицуулан гүйцэтгэсэн болно. Ийнхүү төлөвлөсөн ажлуудыг хийж гүйцэтгэсэн цаг хугацаа, гүйцэтгэгчийн нэрийг дор хүснэгтлэн жагсаав. Үүнд:

Хүснэгт 2. Төслөөр гүйцэтгэсэн ажлын үе шат

Суурь судалгааны төслөөр гүйцэтгэх тодорхой үе шатны ажлууд	Эхлэх, дуусах хугацаа /он, сар, өдөр/	Гүйцэтгэгчийн овог, нэр, мэргэжил
2019 он		
3 жилийн ажлын төлөвлөгөөг гаргаж Эрдмийн зөвлөлөөр батлуулав.	2019.02.25- 2019.02.26	Н.Батболд
Суурь судалгааны төслийн хүрээнд хийж гүйцэтгэх хээрийн судалгааны төлөвлөлтийг хийв.	2019.02.27	Н.Батболд
Өмнөговь аймгийн Сэврэй, Ноён, Баян-Овоо, Номгон, Ханбогд сумд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт хадны зургийн дурсгалт газруудын байрлалыг тогтоох, баримтжуулах хээрийн судалгааны ажлыг амжилттай хийж гүйцэтгэв.	2019.10.02- 2019.10.13	Н.Батболд Ц.Төрбат Н.Эрдэнэ-Очир Ж.Гантулга Ц.Цэлхагарав
Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт ажилласан хээрийн судалгааны ангийн тайлан боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.	2019.11.01 – 2019.12.29	Н.Батболд Ц.Төрбат Н.Эрдэнэ-Очир Ж.Гантулга Ц.Цэлхагарав
“Монголын хадны зургийн нууцаас (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” нэгэн сэдэвт зохиолын төлөвлөгөө гаргав.	2019.11	Н.Батболд
Төслийн багийн бүрэлдэхүүн		Н.Батболд

<p>“Монголын археологи-2019” эрдэм шинжилгээний хуралд сэдвийн дагуу 3 илтгэл хэлэлцүүлэв.</p> <p>“Хэмцэгийн соёлын хадны зураг” эрдэм шинжилгээний өгүүллийг Археологийн судлал сэтгүүлд хэвлүүлэв.</p> <p>“Монголын баруун хойд бүс нутагт хийсэн хадны зургийн судалгаа” эрдэм шинжилгээний өгүүллийг Археологийн судлал сэтгүүлд хэвлүүлэв.</p> <p>“Хойд хөлцөөтийн хадны зураг” эрдэм шинжилгээний өгүүллийг УБ-ын Их сургуулийн Археологи, түүх, угсаатан судлалын сэтгүүлд хэвлүүлэв.</p>	<p>2019.12.25</p> <p>2019</p> <p>2019</p> <p>2019</p>	<p>Ж.Гантулга Ц.Цэлхагарав Н.Эрдэнэ-Очир Ц.Төрбат</p> <p>Ц.Төрбат</p> <p>Н.Батболд, В.И.Молодин, Д.В.Черемисин, Ю.Н.Ненахова.</p> <p>Б.Өмирбек, В.И.Молодин, Н.Батболд, Д.В.Черемисин, Ю.Н.Ненахова, Д.А.Ненахов.</p>
<p style="text-align: center;">2020 он</p> <p>3 жилийн ажлын төлөвлөгөөний дагуу суурь судалгааны төслийн хүрээнд хийж гүйцэтгэх хээрийн судалгааны төлөвлөлтийг хийв.</p> <p>Дорноговь аймгийн Хатанбулаг, Улаанбадрах, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Эрдэнэцагаан, Уулбаян, Түвшинширээ сумдын нутагт суурь судалгааны сэдэвт холбогдох хадны зургийн дурсгалт газруудын байрлалыг тогтоох, баримтжуулах хээрийн судалгааны ажлыг амжилттай хийж гүйцэтгэв.</p> <p>Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт ажилласан хээрийн судалгааны ангийн тайлан боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.</p> <p>“Чулуут-Суман голын хадны зураг” нэгэн сэдэвт зохиолын төлөвлөгөө гаргав.</p>	<p>2020.02.24-25</p> <p>2020.09.16 - 2020.10.05</p> <p>2020.11.01 – 2020.12.20</p> <p>2020.10</p>	<p>Н.Батболд</p> <p>Н.Батболд Г.Галдан Ц.Цэлхагарав</p> <p>Н.Батболд Г.Галдан</p> <p>Н.Батболд,</p>

<p>“Палимпсест с местонахождения Цагаан салаа IV (Монгольский Алтай): относительная хронология изображений” эрдэм шинжилгээний өгүүллийг ОХУ-ын Археологийн хүрээлэнгийн сэтгүүлд хэвлүүлэв.</p>	2020.10	В.И.Молодин, Л.В.Зоткина, К.Кретэн, Д.В.Черемисин, Д.Цэвээндорж. Н.Батболд.
<p>“Төв Азийн хадны зураг ба буган хөшөө” эрдэм шинжилгээний өгүүллийг Археологийн судлал сэтгүүлд хэвлүүлэв.</p>	2020.11	Н.Батболд
<p>Төслийн багийн бүрэлдэхүүн “Монголын археологи-2019” эрдэм шинжилгээний хуралд сэдвийн дагуу нэг илтгэл хэлэлцүүлэв.</p>	2020.12.24	Н.Батболд Г.Галдан
<p>2021 он</p> <p>3 жилийн ажлын төлөвлөгөөний дагуу суурь судалгааны төслийн хүрээнд хийж гүйцэтгэх хээрийн судалгааны төлөвлөлтийг хийв.</p> <p>Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт суурь судалгааны сэдэвт холбогдох хадны зургийн дурсгалт газруудын байрлалыг тогтоох, баримтжуулах хээрийн судалгааны ажлыг амжилттай хийж гүйцэтгэв.</p> <p>Сүхбаатар аймгийн нутагт ажилласан хээрийн судалгааны ангийн тайлан боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.</p> <p>“Хадны зураг дахь янгирын дүрслэл” эрдэм шинжилгээний өгүүллийг УБ-ын Их сургуулийн Археологи, түүх, угсаатан судлалын сэтгүүлд хэвлүүлэв.</p> <p>Төслийн багийн бүрэлдэхүүн “Монголын археологи-2021” эрдэм шинжилгээний хуралд сэдвийн дагуу нэг илтгэл хэлэлцүүлэв.</p>	<p>2021.02.19</p> <p>2021.09.05 - 2021.09.14</p> <p>2021.11.01 – 2021.12.21</p> <p>2021.11</p> <p>2021.12.26</p>	<p>Н.Батболд</p> <p>Н.Батболд Г.Галдан</p> <p>Н.Батболд Г.Галдан</p> <p>Н.Батболд</p> <p>Н.Батболд Г.Галдан</p>
<p>2022 он</p> <p>3 жилийн ажлын төлөвлөгөөний дагуу суурь судалгааны төслийн хүрээнд</p>	2022.02.14	Н.Батболд

хийж гүйцэтгэх хээрийн судалгааны төлөвлөлтийг хийв.		
“Чемурчекские антроморфы” эрдэм шинжилгээний өгүүллийг ОХУ-ын “Stratum plus. Archaeology and Cultural Anthropology” сэтгүүлд хэвлүүлэв.	2022.04	В.И.Молодин, Д.В.Черемисин, Ю.Н.Ненахова, Д.А.Ненахов. Н.Батболд.
Архангай аймгийн Тариат сумын нутаг Чулуут, Суман голын сав нутагт суурь судалгааны сэдэвт холбогдох хадны зургийн дурсгалт газруудын байрлалыг тогтоох, баримтжуулах хээрийн судалгааны ажлыг амжилттай хийж гүйцэтгэв.	2022.08.10- 2022.08.20	Н.Батболд Д.Содномжамц
Архангай аймгийн нутагт ажилласан хээрийн судалгааны ангийн тайлан боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.	2022.10.01 – 2022.12.20	Н.Батболд Д.Содномжамц
“Төв Азийн хүрлийн эхэн үеийн эртний нүүдэлчдийн урлаг” хамтын бүтээл (хурлын эмхэтгэл)-ийг редакторлаж хэвлүүлэв.	2022.11.01- 2022.11.10	Н.Батболд
“Төв Ази ба Умард Хятадын хүрэл зэвсгийн эхэн үеийн эртний нүүдэлчдийн урлаг” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулав.	2022.11.11	Н.Батболд, Д.Содномжамц Д.Батсүх Ц.Цэлхагарав
Төслийн багийн бүрэлдэхүүн “Монголын археологи-2022” эрдэм шинжилгээний хуралд сэдвийн дагуу нэг илтгэл хэлэлцүүлэв.	2022.12.25	Н.Батболд Д.Содномжамц
“Чулуут-Суман голын хадны зураг” нэгэн сэдэвт зохиолыг бичиж хэвлэлийн эх бэлтгэв.	2022.08.15 – 2022.12.29	Н.Батболд Д.Содномжамц
“Монголын хадны зургийн нууцаас (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” нэгэн сэдэвт зохиолыг хэвлүүлэв.	2022.12.28	Н.Батболд Г.Галдан
Сэдэвт ажлын эцсийн тайланг бичиж дуусгав.	2023.02.10	Н.Батболд

Дээрх хүснэгтээс харахад 2019-2022 онуудад хэрэгжсэн энэхүү суурь судалгааны төсөлт ажил нь бүхэлдээ хэд хэдэн шатыг дамжиж хийгдсэн болно. Дөрвөн жилийн хугацаанд хадны зургийн шинэ эх хэрэглэгдэхүүн илрүүлэн олох зорилготой хээрийн шинжилгээний ангийг зохион байгуулан ажиллав. Энэ нь төслийн хамгийн том ажлын нэг байлаа.

Мөн Монголын хадны зургийн судалгааны хувьд харьцангуй бага судлагдсан хүрлийн эхэн үе, түүнээс өмнөх үеийн зургуудыг ялгаж таних, тархцын хүрээг тодорхойлох, зургийн авч хэлэлцэх, судалгааны онол ба арга зүйг харилцан хэлэлцэх, гадаадын салбарын судлаачдын саналыг авах зорилготой эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан нь төслийн нэг чухал ажил болсон юм.

Хээрийн судалгааны ажлын дараа төслийн үр дүнг тусгасан эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, илтгэл хэлэлцүүлэх гэсэн ажлуудыг төслийн оролцогчид хуваарилан авч хийж гүйцэтгэсэн юм.

Төслийн даалгаварын нэгэн томоохон зүйл бол хадны зургийн нэгэн сэдэвт бүтээл туурвих, хэвлэлийн эхийг бэлтгэх ажил байсан юм. Энэхүү ажлыг амжилттай гүйцэтгэсэн нь олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чухал зүйл болсон гэж гэж үзэж байна.

ТАВ. СЭДЭВТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

“Хадны зургийн шинэ судалгаа (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” сэдэвт суурь судалгааны төсөл нь а) хээрийн судалгаа, б) эрдэм шинжилгээний хурал, в) эрдэм шинжилгээний бүтээл гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдсэн гэрээнд тусгагдсан үр дүнгийн даалгаварыг биелүүлэх, тухайлсан нэг цаг үеийн хадны зургийн дурсгалын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бий болгоход анхааран ажиллав.

Энэхүү сэдэвт ажлын хүрээнд хээрийн судалгааны ажлын тайлан 4, эрдэм шинжилгээний өгүүлэл 8, эрдэм шинжилгээний илтгэл 10, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 1, нэгэн сэдэвт бүтээлийн эх бэлтгэл 1, нэгэн сэдэвт бүтээл 1-ийг хэвлэн нийтэлжээ.

Суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд гарсан үр дүнг товч байдлаар доор эрэмбэлэн жагсааж байна.

5.1. Хээрийн судалгааны ажил

Хээрийн судалгааны ажлыг он тус бүрээр товч танилцуулъя.

2019 он.

“Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 02-ноос 13-ны өдрийн хооронд хадны зургийг бүртгэн баримтжуулах, шинээр нээн илрүүлэх ажлыг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбарын ажилтнууд хийж гүйцэтгэв.

Тус суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд Монголын эртний нүүдэлчдийн урлагийн түүхийн төдий л сайн судлагдаагүй бүрхэг хэсэг болох чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үед холбогдож болох хадны зургийн дурсгалууд говийн бүс

нутагт буй мэдээллийг шалгаж, хадны зургийн дурсгалт газрын бүртгэл баримтжуулалтыг өнөөгийн шаардлагын түвшинд нийцүүлэн хийж судалгааны эргэлтэнд оруулах зорилго тавьж ажилласан. Ер нь Монголын эртний нүүдэлчдийн урлагийг тусгайлан судалсан зүйл өнөө хэр хангалттай биш бөгөөд хадны зургийн дурсгалыг олон талаас нь цогцоор судалсан зүйл үгүй байна. Мөн нөгөө талаас өнөө үед ялангуяа говийн бүс нутагт ихээр хөгжиж буй дэд бүтэц, уул уурхай, ашигт малтмал ашиглахтай холбоотой үйл явц болон байгаль экологийн тэнцвэрт бус байдал, хувь хүний санаатай болон санамсаргүй үйл ажиллагааны явцад хадны зургийн дурсгалыг гэмтэж сүйдэхээс нь өмнө амжиж баримтжуулан судлах шаардлага зүй ёсоор урган гарч байгаа юм.

Энэ удаад бид Монголын Говийн бүсийн хадны зураг дахь хүний нүүр дүрсэлсэн зураг бүхий дурсгалт газруудын байршлыг тогтоож баримтжуулахад голлон анхаарч ажиллаа. Ингэхдээ урьд өмнө нь илэрч мэдэгдсэн дурсгалт газруудын мэдээллийг нягталж шалгах, улмаар шинэ дурсгалууд олж илрүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Гурвантэс, Ноён, Номгон, Баян-Овоо, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дахь зарим хадны зургийн дурсгалт газруудад судалгааны ажлыг хийж суурь судалгааны ажилтай холбогдох хадны зургийн байршлыг тогтоож гэрэл зураг авч баримтжуулах ажлыг хийсэн.

Бид Өмнөговь аймгийн нутагт 14, Дорноговь аймгийн нутагт 2, нийт 16 дурсгалт газрын хадны зургийн байршлыг тодорхойлж, бүртгэл баримтжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Хүснэгт 3. Хүний нүүрний дүрс бүхий хадны зургийн дурсгалт газрууд

№	Аймаг	Сум	Газрын нэр
1	Өмнөговь	Гурвантэс	Эрдэнэ хайрхан
2		Ноён	Ихэр гашуун
3		Номгон	Хахуулын гол
4		Номгон	Худгийн сайр
5		Номгон	Цагаан дэрсний Бичиггийн ус
6		Номгон	Цагаан усны гол
7		Номгон	Худгийн бичээс
8		Номгон	Уртын булаг
9		Баян-Овоо	Зовийн гол
10		Баян-Овоо	Хачивч
11		Ханбогд	Хацавчийн гол
12		Ханбогд	Зүүн хацавч
13		Ханбогд	Далайн дуулга
14		Ханбогд	Жавхлант хайрхан
15	Дорноговь	Хатанбулаг	Баруун бичиггийн адаг ус
16		Хатанбулаг	Цохион хонд

Дурсгалуудын тархалтын зургаас харахад Монголын говийн бүсийн хадны зураг дахь хүний нүүрний хэлбэр төрхийг дүрсэлсэн зураг шүтлэг бишрэлийн сэдэвтэй өвөрмөц дүрслэлийн нэгэнд зүй ёсоор тооцогдох нь тодорхой байна.

Эдгээрээс хүний нүүрний багийг нэг дор олноор нь дүрсэлсэн хамгийн том дурсгалт газар бол одоогийн байдлаар Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг дахь Цагаан дэрсний Бичигтийн усны хадны зургийн дурсгалт газар юм. Уг дурсгалт газар нь говийн хадархаг намхан уул толгод, тэдгээрийн хоорондох элсэрхэг хуурай сайр бүхий Монгол улсын өмнөд хилийн бүсэд оршино. Энэ газрыг урьд нь Т.Санжмятав¹⁶, Ч.Амартүвшин, Б.Батдалай¹⁷ нар үзэж судалгааны эргэлтэнд оруулсан байх боловч газар усны нэрийн хувьд ихээхэн зөрөөтэй өөр өөрөөр тэмдэглэсэн байх ажээ. Тухайлбал, Т.Санжмятав Цагаан дэрсний Бичигтийн ус, Ч.Амартүвшин, Б.Батдалай нар Бичигт усны хонд хэмээн тайландаа бичсэн бол бидэнд газарчилсан хилийн заставын дарга хадны зургийн дурсгал байгаа газрыг Бичигтийн гурван овоо гэж ерөнхийд нь нэрлэдэг хэмээсэн юм. Энэхүү дурсгалт газар хойноос урагш чиглэсэн том сайрын дунд хэсэгт зүүн хойноос баруун урагш чиглэн хошуурсан хойд талаараа цавчим хад бүхий ууланд оршино. Хүний нүүрний баг бүхий хадны зургууд тус уулын баруун хойш сайр руу харсан хаднуудад дүрслэгдсэн байна (Зураг 1, 2, 3, 6). Тус сайрыг Бичигтийн ус, сайрын эргэн тойронд буй уулсыг нийтэд нь Бичигтийн Гурван овоо хэмээн нэрлэдэг байна. Иймээс энэхүү дурсгалт газрын нэрийг анх судалгааны эргэлтэнд оруулсан Цагаан дэрсний Бичигтийн ус хэмээн нэрлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

Мөн Хахуулын голын хадны зургийг анх археологич У.Эрдэнэбат¹⁸ судалгааны эргэлтэнд оруулсан. Харин Соёлын өвийн үндэсний төвийн эрхлэн гаргасан “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” цувралын XII дэвтэрт Тоонтын салаагийн усны хадны зураг¹⁹ хэмээн тэмдэглэсэн байна. Энэхүү хоёр талаараа хадтай толгод бүхий голын хуурай сайрын дунд хэсэгт Хахуул хэмээх хадан толгой орших тул анх судалгааны эргэлтэнд оруулсан нэрээр нь цаашид Хахуулын голын хадны зураг хэмээн нэрлэх нь зүйтэй юм.

Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг хилийн зурваст буй Бичигтийн хадны зургийг дээрх номонд Гурван бичигтийн хадны зураг²⁰ гэж оруулсан байна. Анх тус газрыг судлаач Т.Санжмятав²¹ Худгийн бичээс гэж судалгааны эргэлтэнд оруулсан байна. Одоо ашиглахаа больж орхигдсон нэгэн гар худгийн дэргэд буй хадны зураг бүхий бяцхан уулыг Бичигт уул хэмээн нэрлэдэг ажээ. Гэхдээ анх судалгааны эргэлтэнд оруулсан Худгийн бичээс гэсэн нэрийг барих нь зүйтэй юм. Мөн түүнчлэн Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Зовийн гол²², Дорноговь аймгийн

¹⁶ Т.Санжмятав. Өмнөговь аймагт хайгуул хийсэн ажлын тайлан. //Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан (1986-1987). VI боть. Улаанбаатар, 2016, тал 368-371.

¹⁷ Ч.Амартүвшин, Б.Батдалай, Б.Дашизэвэг. Номгон сумын нутагт орших Бичигт усны хондны хадны зураг. Улаанбаатар, 2018.

¹⁸ У.Эрдэнэбат. Хахуулын голын хадны зураг. //Археологийн судлал. Т. (VI) XXVI, fasc. 3. Улаанбаатар. 2008. тал 32-56.

¹⁹ Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XII дэвтэр, Өмнөговь аймаг. Улаанбаатар. 2019. тал 68.

²⁰ Г.Анхсанаа, Г.Энхбат, А.Цоож. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. XII дэвтэр, Өмнөговь аймаг. Улаанбаатар. 2019. тал 66.

²¹ Т.Санжмятав. Өмнөговь аймагт хайгуул хийсэн ажлын тайлан. //Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан (1986-1987). VI боть. Улаанбаатар, 2016, тал 368-371; Т.Санжмятав. Монголын хадны зураг. Улаанбаатар. 1995. тал 45.

²² Ч.Амартүвшин, Б.Батдалай. “Өв эрдэнэ” төсөл: Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт хийгдсэн археологийн хайгуулын ажлын тайлан. Улаанбаатар. 2019.

Хатанбулаг сумын Цохион хонд зэрэг газрын хадны зургийн дурсгалууд дүрслэл, утга санааны хувьд ихээхэн сонирхолтой нарийвчлан судлах шаардлагатай дурсгалууд юм.

Эрдэнэ хайрхан, Ихэр гашуун, Бичигт уул, Цагаан дэрсний Бичигтийн ус, Цагаан усны гол, Жавхлант хайрхан, Далайн дуулга, Зүүн хацавч, Уртын булаг, Зовийн гол, Хачивч, Цохион хонд зэрэг говийн хадны зургуудад хүний нүүрний багийг дүрсэлсэн нь Монголын говийн бүс нутгийн хадны зургийн нэг онцлог хэмээн үзэж болно.

Хад чулуунаа хүний нүүрний баг дүрслэх заншил Төв, Дундад, Хойд Азийн эртний хүмүүсийн дунд түгээмэл байсныг археологийн судалгаагаар нэгэнт олж тогтоосон байдаг. Үүнд Тувагийн Мугур-Саргол²³, Амар мөрний доод урсгал²⁴, Хятадын Иньшань (Мони) уулын²⁵ хадны зураг дахь багны дүрслэлийг дурдаж болно. Мөн Хойд Америкийн Кейп Мьюдж, Вэнн Пэссадж, Форт Руперт, Ретёрн Ченнел, Торсен Крик, Кемпбелл гол, Кича Поинт, Феодесия Инлет зэрэг газарт хүний нүүрний багны зураг байдгийг Е.А.Окладникова ишлэн дурдсныг судлаачид тэмдэглэсэн байдаг²⁶.

Сүүлийн жилүүдэд явуулсан судалгаагаар манай орны баруун хэсэг Монгол Алтайн Цагаан салаа, Бага Ойгорын хаданд дүрсэлсэн 10 гаруй багны зургийг илрүүлэн олжээ²⁷.

Хад чулуунаа хүний нүүрний баг дүрслэх явдал нь эртний хүмүүсийн сүсэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл, тодорхой төрлийн зан үйлтэй салшгүй холбоотой. Дээр өгүүлсэн хадны зураг дахь хүний нүүрний багтай төстэй дүрс Хэнтий аймгийн ОНСМузейн үзмэрт байгаа бөөгийн хувцсанд зүүсэн эврэн сав, тунраа дээр урлагдсан байдаг²⁸ нь энэ төрлийн зургууд бөө мөргөлтэй холбоотойг харуулж буй баримт юм. Мөн Говийн бүсийн зарим зургууд тухайлбал, Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаан дэрсний Бичигтийн усны хүний нүүрний баг олон давхарлагдаж зурагдсан нь ч тахилга шүтлэгтэй холбоотойг илэрхийлнэ (Зураг 6).

Ийнхүү Монголын Говийн бүс нутаг дахь хүний нүүрний хэлбэр төрх бүхий хадны зургийн дурсгалт газруудыг бүртгэн баримтжуулсан нь энэ төрлийн өвөрмөц дүрслэлтэй дурсгалуудын тархалт, хамрах хүрээг тогтооход чухал ач холбогдолтой ажил болсон хэмээн үзэж байна.

²³ М.А.Дэвлет. *Петроглифы Мугур-Саргола*. Москва. 1980. стр. 10, рис. 4, 17.


²⁴ А.П.Окладников. *Лики древнего Амура*. Новосибирск. 1968. стр 51.

²⁵ 盖山林. *阴山岩画*. 北京. 1986: тал 259 (*Gai Shanlin. Petroglyphs in the Yinshan Mountains. – Beijing*) (in English abstr.).


²⁶ Д.Цэвээндорж, Я.Цэрэндагва, Б.Гүнчинсүрэн, Д.Гарамжав. *Жавхлант хайрханы хадны зураг*. Улаанбаатар. 2004. Тал 85.

²⁷ В.Д.Кубарев, Д.Цэвээндорж, Э.Якобсон. *Петроглифы Цагаан салаа и Бага-Ойгура (Монгольский Алтай)*. Новосибирск-Улаанбаатар-Юджин. 2005. стр. 76, 560, рис. 70.

²⁸ Т.Санжмятав. *Монголын хадны зураг*. Улаанбаатар. 1995. тал 46.



Зураг 1. Судалгаа хийсэн дурсгалт газруудын байршил



Зураг 2. Цагаан дэрсний Бичигтийн усны хадны зургийн дурсгалт газрын ерөнхий байдал



Зураг 3. Цагаан дэрсний Бичигтийн усны хадны зургийн хэсгээс



Зураг 4. Худгийн бичээсийн хадны зургийн хэсгээс



Зураг 5. Цагаан дэрсний Бичигтийн усны хадны зургийн хэсгээс

Ширээгийн ар зэрэг газраас урьд тэмдэглэгдээгүй цөөн дүрслэл нэмж бүртгэснээс гадна Улаанбадрах сумын нутгаас Бичигтийн бууц 1, 2, Тойромын усны бууц, Цагаан дов зэрэг газруудаас нутгийн малчин н.Долгорсүрэн, н.Энхбаяр нарын мэдээлснээр шинээр цөөн тооны дүрслэлтэй хадны зургийн дурсгалуудыг илрүүлэн бүртгэсэн. Мөн 2020 оны хавар Сүхбаатар аймгийн Онгон сумын Бударын чулуу хэмээх газраас Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей, тус аймгийн Соёл, урлагийн газрынхан шинээр хадны зураг илрүүлсэн мэдээг шалган тус газарт очин тухайн шинээр илрүүлсэн хадны зосон зургийн дурсгалын баримтжуулалт хийсний зэрэгцээ тус аймгийн Уулбаян сумын Бор хайрхан хэмээх газарт бүртгэгдсэн хадны зосон зургийн баримтжуулалт хийх явцдаа шинээр нэмж хэд хэдэн дүрслэл нэмж олж бүртгэв.

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан хадны зургийн дурсгалууд

№	Аймаг	Сум	Газрын нэр
1	Дорноговь	Сайхандулаан	Ар хар овоо
2			Сүүдэртийн овоо
3		Мандах	Хавцгайн гол
4			Номтын бууц
5		Хатанбулаг	Эхэн хөв
6			Бумбатын ус
7			Ухаа хошуу
8			Тэмээн чулууны гол
9			Ширээгийн ар
10			Цохион хонд
11			Зүүн бичигт
12			Хөх цав
13			Давхар хад
14			Үнэгтийн цагааны баруун тамгатай овоо
15		Баруун эрэг	
16		Хөвсгөл	Хар дэл
17		Улаанбадрах	Тойром усны бууц
18			Тойромын ус (1)
19			Цагаан дугуй бууц
20			Бичигтийн бууц-1
21			Бичигтийн бууц-2
22			Цагаан дов
24	Сүхбаатар	Баяндэлгэр	Хужирт
25		Онгон	Бударын чулуу-1 (сийлмэл зураг)
26			Бударын чулуу-2 (зосон зураг)
27		Эрдэнэцагаан	Жаргалантын адгийн ширээ
28		Уулбаян	Хангай хад
29			Бор хайрхан
30		Түвшинширээ	Цагаан элэг
31			Адгийн гол
32			Хадны ус

“Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд хийсэн хайгуул судалгаагаар Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт хадны зургийн 32 дурсгалт газрын бүртгэл баримтжуулалтыг дахин хийлээ.

Эдгээр дурсгалт газруудын он цаг түүхийн олон үед хамаарах нь дүр дүрслэл, арга барил зэргээр танигдаж байгаа бөгөөд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Эхэн хөв, Бумбатын ус, Ширээгийн ар, Баруун эрэг, Улаанбадрах сумын Цагаан дугуй бууц зэрэг дурсгалууд дүр дүрслэлийн хувьд бидний судалгааны ажлын үндсэн чиглэлүүдийн нэг болох чулуун зэвсгийн сүүл, хүрэл зэвсгийн эхэн үед хамаарч болзошгүйг дурдах нь зүйтэй юм.

Ийнхүү Монголын Говь болон зүүн бүс нутаг дахь чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үед холбогдож болох хадны зургийн дурсгалт газруудыг бүртгэн баримтжуулсан нь энэ төрлийн өвөрмөц дүрслэлтэй дурсгалуудын тархалт, хамрах хүрээг тогтооход чухал ач холбогдолтой ажил болсон хэмээн үзэж байна.

2021 он.

“Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд 2021 оны 9 дүгээр сарын 05-наас 14-ний өдрийн хооронд Сүхбаатар аймгийн нутагт буй төсөлт ажилтай холбогдох хадны зургийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, шинээр нээн илрүүлэх ажлыг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Хүннү ба эртний улсуудын судалгааны салбар болон Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбарын ажилтнууд хийж гүйцэтгэв. Судалгааны багт Хүннү ба эртний улсуудын судалгааны салбарын эрхлэгч, доктор /Ph/ Н.Батболд, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Галдан, С.Энхболд, Хүрэл ба төмрийн үеийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор /Ph/ Ж.Гантулга, магистр Д.Батсүх, Ц.Цэлхагарав, Археологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор /Ph/ Н.Эрдэнэ-Очир нар оролцон ажилласан.

Суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд энэ жил Архангай аймгийн Тариат сумын Чулуут голын хөндий, Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт хадны зургийн хайгуул хийж улмаар дурсгалт газрын дэргэд буй булш оршуулгын дурсгалыг малтан судалж илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнийг харьцуулан нарийвчлан судлах, он цагийг байгалийн шинжлэх ухааны судалгааны үр дүнд тулгуурлан тогтоох зорилготой байсан боловч улс орон даяар үүссэн халдварт өвчний нөхцөл байдлаас шалтгаалан санхүүжилт дутуу хийгдсэн тул төлөвлөсөн ажлаа гүйцэтгэж чадаагүй болно. Хэдий тийм боловч олгогдсон санхүүжилтын хүрээнд Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Бударын чулуу хэмээх газарт судалгааны ажлыг хийлээ.

Энэ удаад бид Бударын чулуунд буй археологийн дурсгалуудын байршлыг тогтоож бүртгэн баримтжуулахад голлон анхаарч ажиллалаа.


Сүхбаатар аймгийн Онгон сумын нутгийн өмнөд зах Монгол Улс, БНХАУ-ын хоорондын улсын хил дээр байдаг сонин тогтоцтой, их, бага хэмжээтэй олон тооны боржин чулуун цохионуудыг Бударын чулуу хэмээн нэрлэдэг. Эдгээр цохионуудын үргэлжлэл хэсэг нь БНХАУ-ын нутагт оршино.

Бударын чулууны баруун захаас баруун зүгт арваад км-т Баянтөхөмийн говь дотор сондгой ганц өндөрлөг байдаг бөгөөд үүнийг Төхөмийн бор овоо гэж

нэрлэдэг. Эрт дээр цаг их цэрэг дорно зүгт давшиж энэ нутагт ирээд жанжин нь үлдэж хоцорсон учир цэргүүд нь жанжнаа хүлээгээд тэндээ үлджээ. Ингээд жанжин нь Төхөмийн бор овоо, цэргүүд нь Бударын чулуу болсон гэсэн домог байдаг ажээ.

Мөн 2020 оны хавар Сүхбаатар аймгийн Онгон сумын Бударын чулуу хэмээх газраас Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей, тус аймгийн Соёл, урлагийн газрынхан шинээр хадны зураг илрүүлсэн мэдээг шалган тус газарт очин тухайн шинээр илрүүлсэн хадны зосон зургийн дурсгалын баримтжуулалт хийсний зэрэгцээ шинээр нэмж хэд хэдэн зосон зураг болон сийлмэл зургийн дүрслэл нэмж олж бүртгэв.

“Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд хийсэн хайгуул судалгаагаар Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Бударын чулуунд 68 хайгуулын цэгт нийт 100 гаруй археологийн дурсгал илрүүлэн бүртгэл баримтжуулалтыг хийлээ.



Зураг 7. Газрын зураг. Бударын чулууны дурсгалт газарт буй археологийн дурсгалууд

“Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд хийсэн хайгуул судалгаагаар Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Бударын чулуунд 68 хайгуулын цэгт нийт 100 гаруй археологийн дурсгал илрүүлэн бүртгэл баримтжуулалтыг хийлээ.

Хилийн заставаас хойш 3,8 км зайтай Бударын чулууны дунд хадны сийлмэл зургийн дурсгал бий. Энэ нь нэгэн том ханан хаднаа хоёр хэсэг газар хүн, адуу мал, ан амьтдын дүрсийг бүх талбайгаар нь хонхойлгон цохиж сийлсэн зураг юм. Энэ дурсгалыг 1996 онд Монгол, Солонгосын хамтарсан “Дорнод Монгол” төслийн хээрийн шинжилгээний анги илрүүлэн судалжээ.

Эндэхийн хадны зурагт морь, нохой хөтөлсөн, хоорондоо хөтлөлцсөн, хөөцөлдсөн, ноцолдож байгаа, давхарлан хэвтсэн зэргээр хүний дүрсийг олон тоогоор дүрсэлсэн байна. Мөн шат маягийн хөндлөвчтэй босоо зураас бүхий зураг нь дөрвөлжин булшны соёлыг үлдээгчдийн оршуулгын зан үйлтэй холбоотой сонирхолтой өгүүлэмж юм. Бударын чулуунд 10 орчим дөрвөлжин булш бүртгэгдсэн нь энэ хадны зургийн утга агуулгатай холбоотой байх магадлал өндөр байна.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Бударын чулууны дөрвөлжин булш нь тухайн газрын зосон зургийн дурсгалтай хамт байх ба тэдгээрийн зүүн талд уртрагийн дагуу байрлуулсан дөрвөн өнцөгтэй, зүүн талдаа үүд маягийн тасархайтай тахилын бололтой чулуун байгууламж 40 орчим байна. Эдгээр байгууламжууд нь хэмжээний хувьд харилцан адилгүй боловч бүтцийн хувьд бүгд ижил байна. Үүнтэй ижил дурсгал тус аймгийн Мөнххаан, Түвшинширээ, Уулбаян сумдуудад бүртгэгдсэн байдаг. Ийм төрлийн дурсгалыг малтан судлахад ямар нэгэн олдвор илэрч олддоггүй ажээ.

Хүснэгт 5. Хайгуулаар бүртгэсэн дурсгалууд

Бударын чулуу		
№	Дурсгалын төрөл	Тоо хэмжээ
1	Дөрвөлжин булш	13
2	Хадны зураг	11
3	Улаан зуух хэлбэрийн булш	9
4	Чулуун байгууламж	51
5	Монгол булш	1
6	Дугуй булш	8
7	Ваар, чулуун зэвсгийн түүвэр олдвор бүхий газар	8
	Нийт	101



Зураг 8. Шинээр илрүүлсэн хадны зосон зургууд

Монголын зүүн бүс нутагт хадны зосон зургийн дурсгалууд шинээр нээн илрүүлсэн нь тэдгээрийн тархалт, хамрах хүрээг тогтооход чухал ач холбогдолтой ажил болсон хэмээн үзэж байна. Цаашид энэхүү судалгааг илүү нарийвчлан хийх шаардлагатай юм.

2022 он.

Улс орон даяар үүссэн халдварт өвчний нөхцөл байдлын улмаас санхүүжилт тасалдсан тул тус төслийг 2022 оныг дуустал сунгасан болно. Дутуу

байсан санхүүжилт 2021 оны 12-р сарын 16-нд хийгдсэн тул төслийн үлдсэн ажлуудыг 2022 онд хийхээр төлөвлөсний дагуу ажиллалаа.

“Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд 2022 оны 8 дугаар сарын 05-наас 15-ний өдрийн хооронд Архангай аймгийн Тариат сумын нутаг Суман, Чулуут голын савд буй төсөлт ажилтай холбогдох хадны зургийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, шинээр нээн илрүүлэх ажлыг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбарын ажилтнууд хийж гүйцэтгэв. Судалгааны багт Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбарын эрхлэгч, доктор /Ph/ Н.Батболд, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Д.Содномжамц, гэрээт ажилтан Б.Буян-Орших нар оролцон ажилласан.

Энэхүү суурь судалгааны төслийн хүрээнд Монголын чулуун зэвсгээс хүрлийн эхэн үеийн эртний нүүдэлчдийн урлагийн түүхийн төдий л сайн судлагдаагүй бүрхэг хэсгийг нарийвчлан судлах зорилгоор Архангай аймгийн нутагт буй чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үед холбогдох хадны зургийн хайгуул хийх, тухайн үеийн археологийн дурсгалын мэдээллийн сан бүрдүүлэх баримт мэдээлэл цуглуулах, тухайн бүс нутгийн хадны зургийн дурсгалуудыг бусад бүс нутгийн дурсгалуудтай харьцуулан судлах зорилт тавин ажилласан. Хээрийн судалгаа хийснээр судалгааны ажлын үр дүнг хэвлэн нийтлэх, номын эх бэлтгэх материалуудыг бүрдүүлэх юм.

2022 онд Архангай аймгийн Тариат сумын Чулуут голын хөндийд хадны зургийн хайгуул хийж улмаар дурсгалт газрын дэргэд буй булш оршуулгын дурсгалыг малтан судалж илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнийг харьцуулан нарийвчлан судлах, он цагийг байгалийн шинжлэх ухааны судалгааны үр дүнд тулгуурлан тогтоох зорилготой судалгааны ажлыг хийлээ.

Судалгааны ажлын хүрээнд Чулуут голын Аваргын буланд хадны зураг бүхий хавтан чулууны өмнө талд бага хэмжээний зорилтын малтлага хийж шинэ чулуун зэвсгийн үед хамаарах чулуун зэвсгийн залтас 1 ширхэг, хүрлийн эхэн үед холбогдож болох шавар савны хагархай 2 ширхэг зэргийг илрүүлсэн явдал тухайн бүс нутагт суурьшин амьдарч байсан эртний хүмүүсийн үлдээсэн эд өлгийн зүйлс болох нь эргэлзээгүй юм. Малтлагын ажлын гол зорилго нь тухайн хадны зургийг сийлэх явцад хагарч бутарч үлдсэн чулуун багаж зэвсгийн үлдэгдлийг хайж илрүүлэхэд оршиж байсан ба хэрэв цаашид өргөн хэмжээний малтлагын ажлыг үргэлжлүүлэн хийвэл тодорхой хэмжээний үр дүнд хүрч болохыг энэхүү сорилтын малтлага харуулж байна.

Чулуутын гол нь Хангайн нурууны Эгийн давааны орчим Гурван Ангархай уулын ар талаас эх аван Архангай аймгийн Чулуут, Тариат, Жаргалант, Цэцэрлэг сумдын нутгаар дайран 415 км урсаж Идэрийн голд цутгадаг манай орны томоохон голуудын нэг юм. Чулуут голын хөндий эхэндээ давчуу, морены бул чулуу элбэгтэй бол доошлох тусам өргөсөж тэлэгддэг. Тээлийн голын бэлчрээс Ацтийн горхины цутгал хүртэлх 100 орчим км урт газарт 50-60 м зузаан хүрмэн чулууг зүсэж хавцал дундуур тахирлан хүрхрээ боргио үүсгэн сүртэй урсдаг. Голын усны төвшин Тэрхийн цагаан нуураас эх авч урсах Суман голтой нийлэх хэсэгт эрс нэмэгддэг онцлогтой [Цэгмид 1969: 165]. Чулуут голын сав дагууд зэрлэг ан амьтан, загас жараахай элбэг тул хүмүүс эртнээс нааш хавцлын дагууд амьдарч байсныг илтгэх хадны зураг, булш оршуулгын дурсгал ихтэй. Эдгээр бүх дурсгалыг бүртгэн

баримтжуулж судалгааны ажил гүйцэтгэхэд цаг хугацаа, хөрөнгө санхүү ихээхэн шаардагдах хэдий ч бид боломжийн хэрээр тус

Монголын төвийн бүс нутаг нэн ялангуяа Чулуут болон Суман голын хөндий нь чулуун зэвсгийн сүүл, хүрлийн түрүү үед холбогдож болох олон тооны хадны зургийн гол төвлөрөл болсон чухал дурсгалт газарт зүй ёсоор тооцогдоно. Тиймээс ч 1980 оноос эхлэн хадны зураг судлагч гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид удаа дараа очиж судалгааны эргэлтэд оруулах зорилгоор хайгуул судалгааны ажил хийж, үр дүнг хэвлэн нийтэлсэн байдаг. Гэвч Чулуут-Суман голын хадны зураг харьцангуй судлагдсан мэт харагдах боловч цогцоор нь авч үзсэн системтэй судалгаа одоог хүртэл хийгдээгүйн зэрэгцээ өмнөх судлаачдын тогтоосон дурсгалт газруудын байршил болон газрын нэр тодорхой бус зөрүүтэй байна. Мөн судлаачдын хэвлүүлсэн гар зурган хуулбаруудын итгэмжтэй байдал эргэлзээ төрүүлж байгаа нь хамгийн ноцтой асуудал болно. Энэ нь цэвэр техникийн шинжтэй алдааны үр дүн байж болох хэдий ч зайлшгүй дээрх зургуудыг дахин олж гэрэл зураг болон видео бичлэгээр баримтжуулж байж цаашид ашиглах бололцоотой болох юм.

Иймээс бид урьд өмнө нь илэрч мэдэгдсэн дурсгалт газруудын мэдээллийг нягталж шалгах, улмаар шинэ дурсгалууд олж илрүүлэх зорилгоор Архангай аймгийн Тариат, Жаргалант сумдын нутгаар дайран урсах Чулуут голын сав дагууд төвлөрч хадны зургийн дурсгалт газрын байршлыг тогтоож гэрэл зураг авч баримтжуулах ажлыг хийж гүйцэтгэв. Ингэхдээ дурсгалт газрын нэрийг тодруулахдаа нутгийн уугуул хэд хэдэн хүнээс давхар аман мэдээ авсны үндсэн дээр эцэслэж нарийвчлан тогтоов. Өндөр цавчим хадан хясаа болон ширүүн урсгалт боргио ихтэй тул хайгуул судалгааны ажил хийж гүйцэтгэхэд бартаа саад ихтэйн зэрэгцээ зарим газарт зөвхөн өвлийн улиралд очих боломжтой байдаг. Ерөнхийдөө гол 11-р сарын дундаас эхлэн хадаалдаг бол 4-р сарын сүүлээр мөс бүрэн хайлдаг бөгөөд нутгийн иргэд өвөл 12-р сараас 02-р сарын хооронд голын мөсөн дээгүүр зорчдог байна. Тиймээс бид зарим дурсгалыг өвөл гол хөлдүү байх үед очиж бүртгэсэн юм.

Хадны зургийн хайгуул судалгааны ажлын явцад Архангай аймгийн Тариат сумын Суман голын хөндийд Хамрын булан, Цагаан асгын бөөн хад, Долгорын булан, Чимэдийн булан, Бухтын булан зэрэг 5 газар, Чулуут голын хөндийд Давхарын булан, Хамрын булан, Ар булан, Аваргын булан, Рашааны хөл, Ёлын булан, Өндөр хар зэрэг 7 газар, нийт 12 дурсгалт газрын хадны зургийн байршлыг тодорхойлж, бүртгэл баримтжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн юм. Эдгээр дурсгалт газрууд нь ихэвчлэн голын эрэгт дагуух газруудад тархсан бөгөөд хадны зургууд нь галт уулын гаралтай хүрмэн чулуун хаданд сийлэгдсэн учир зарим зургууд нэлээд бүдгэрсэн байна. Дээрх дурсгалт газруудын ихэнхийг нь өмнөх судлаачид нэгэнт бүртгэсэн байсан хэдий ч шинээр олон тооны зургийг нэмж баримтжуулсны зэрэгцээ Бухтын булан болон Өндөр хар зэрэг дурсгалт газруудыг шинээр бүртгэснийг тэмдэглэх хэрэгтэй. Мөн 1995 онд Т.Санжмятав гуайн хэвлүүлсэн “Монголын хадны зураг” хэмээх бүтээлд Ёлын булан гэсэн газарт бүртгэсэн зургийн хуулбарыг хадны зурагтай газарт нь очиж тулгаж үзэхэд зарим талаараа нэлээд зөрүүтэйн зэрэгцээ, тухайн газрыг нутгийн ардууд Аваргын булан хэмээн нэрлэдэг аж. Энэ мэтчилэн олон зөрүүтэй зүйл ажиглагдсан хэдий ч


судлаачдын тухайн үед ашиглагдаж байсан багаж хэрэгслийн боломжоос хамаарч иймэрхүү техник алдаанууд гарч байсныг үгүйсгэх аргагүй юм.

Чулуут болон Суман голын хөндийд тархсан хадны зургууд дотроос их биеийг хөвөөлдөн цохих аргаар зурсан хүний өвөрмөц дүрслэл, төрж буй эмэгтэй, эрээн биетэй үхэр болон буга зэрэг чулуун зэвсгийн сүүл, хүрлийн эхэн үеийн Монгол орны хадны зургийн судалгааны чухал материал болсоор байна. Түүнчлэн хүрлийн хожуу, төмрийн түрүү үеийн амьтны загварт урлагийн аргаар зурсан олон тооны ан амьтдын дүрслэл, Хүннү болон Түрэг, Уйгурын үеийн тамга тэмдгийн дүрслэлүүд ч мөн адил судалгааны чухал харьцуулалт болохыг онцлон дурдах нь зүйтэй.

Чулуут болон Суман голын сав дагууд тархсан хадны зургийн дурсгалт газруудыг доор хүснэгтэд үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 6. Чулуут болон Суман голын хадны зургийн дурсгалт газрууд

№	Аймаг, сум	Сум	Газрын нэр
1	Архангай	Тариат	Хамрын булан
2		Тариат	Цагаан асгын бөөн хад
3		Тариат	Долгорын булан
4		Тариат	Чимэдийн булан
5		Тариат	Олгой
6		Тариат	Бухтын булан
7		Тариат	Давхарын булан
8		Тариат	Хамрын булан
9		Жаргалант	Ар булан
10		Тариат	Аваргын булан
11		Жаргалант	Рашааны хөл
12		Жаргалант	Ёлын булан
13		Тариат	Өндөр хар



Зураг 9. Хадны зургийн дурсгалт газруудын байршил


Чулуут голын Аваргын буланд хийсэн малтлага судалгаа

Дурсгалт газрын байршил: N48 28 36.1 E100 33 57.8 ДТД 1560 м

Чулуут голын хөндий нь түүхийн олон үед хамаарах археологийн дурсгалаар нэн баялаг бүс нутгийн нэг бөгөөд байгалийн тогтцын хувьд дөрөвдөгч галавын үеийн хүрмэн чулуулаг болон галт уулын гаралтай чулуулгийн зузаан тархацтай. Чулуут голд Суман, Азарга, Шаргачин, Даага, Асайт, Алтайд, Чингэстэй зэрэг жижиг голууд нийлж цутгах ба эдгээр жижиг голуудын хөндийгөөр мөн олон тооны дурсгал бий. Одоогийн байдлаар Чулуут голын сав дагууд Олгой, Давхарын булан, Ар булан, Аваргын булан, Рашааны хөл, Ёлын булан гэсэн 6 дурсгалт газарт хадны зургийн бүртгэн баримтжуулалт хийжээ.

Энэ удаагийн хайгуул, малтлага судалгааны ажлыг Архангай аймгийн Тариат сумын нутаг Чулуут голын Аваргын булан хэмээх газарт төвлөрөн хийж гүйцэтгэв. Аваргын булан нь Тариат сумын төвөөс баруун хойд зүгт 60 км зайд орших бөгөөд Чулуут гол хойш эргэн тохойрсон хэсэгт урт талаас Асайтын гол, зүүн хойд талаас нь Алингар болон Алтайдын гол нийлж цутгадаг. Алтайдын гол болон Чулуут голын хоорондох тэгш өндөрлөгийг Наймганы тал хэмээн нэрлэдэг. Наймганы талын урд үзүүр хэсэг болох Чулуут гол руу шахаж орсон тохойг Аваргын булан гэнэ.

Аваргын булан орчимд голын хавцал задгайрч тэгш хөндий залгах ба энэхүү тохойн хойд талын эргийн хөвөө хэсгийн хүрмэн чулуун хаданд олон тооны хадны зурагтай.



Зураг 10. Малтлага болон хайгуул судалгаа хийсэн дурсгалт газрын байршил

Бид Чулуут голын сав дагууд хадны зургийн хайгуул судалгааны ажил хийж гүйцэтгэхийн зэрэгцээ зарим газарт хүн суурьшсан амьдарч байсан ул мөрийг илрүүлэх төдийгүй хадны зургийг цохиж сийлэх явцад хагарч бутарч үлдсэн чулуун багаж зэвсгийн үлдэгдлийг хайх зорилгоор бага хэмжээний газарт сорилтын малтлага хийхээр төлөвлөсөн юм. Энэ удаагийн малтлага судалгааг Чулуут голын хойд эрэг болох Аваргын булангийн баруун урд захад, гол руу шахаж байрласан хадны зураг бүхий нэгэн хавтан чулууны урд талд 140 x 90 см хэмжээтэй сонгон авч хийв. Малтлагын ажлыг хүн хүч, цаг хугацааны байдлаас хамаарч харьцангуй жижиг талбайг сонгон хийсэн боловч тодорхой хэмжээний үр дүнд хүрэв. Малтлага хийсэн талбайн ойр орчимд хийсэн хайгуул судалгааны явцад улаан хүрэн өнгөтэй, дээрээ дусал маягийн дармал хээтэй ваарны их бие хэсгийн 3 x 1,5 x 0,7 см хэмжээтэй хагархай 1 ширхэг олдov.

Малтлага хийсэн хадны зураг бүхий хавтан чулуу нь 160 см урт, 150 см өргөн, 65 см зузаантай бөгөөд галт уулын гаралтай хүрмэн чулуу юм. Хадны зургийг уг чулууны дээш харсан толигор гадаргуу дээр дүрслэлийг бүх талбайгаар нь хонхойлгон цохих аргаар сийлжээ. Хадны зүүн дээд буланд мөөгөн хэлбэрийн малгайтай, гартаа нум сум агссан харваж буй хүнийг дүрсэлсэн ба сумны үзүүр хэсгийн зэвний хоёр сөргүүрийг уран нарийн сийлж гаргажээ. Мөн энэ хүн бүснээсээ урт иштэй зээтүү маягийн багаж зүүж, хоёр хөлөө өвдөг орчмоор бага зэрэг нугалан зогсож буйгаар дүрслэн харуулжээ. Хүний их бие хэсгийг эрээлж цохисон нь хувцас аль эсвэл хуяг дүрсэлсэн байж болох юм.

Энэ хүний доод талд нум сумаар гахайтай төстэй бөөрөнхий биетэй, соотон чихтэй, урт хошуутай сүүлээ дээш моодойлгон өргөсөн нэгэн өвөрмөц амьтан болон дэрвэгэр эвэртэй нэг янгирыг анчнаас урагш зугтаж буйгаар зуржээ.

Эдгээрийн ар талд мөн дээрхтэй ижил аргаар нум сумтай анчин гахай харваж буйгаар тэдгээрийн ар талд 2 ширхэг янгирыг тус тус дүрсэлжээ.

Дээрх дүрслэлүүдийн доод талд мөөгөн хэлбэрийн малгай эсвэл дуулга өмсөж, нум барин зогсож буй 6 хүн, дээд талд бодит дүрслэлтэй буга, хүмүүсийн урд талд бүсэндээ саадаг агсаж, морь хөтлөн зогсож буй нэг хүнийг тус тус дүрсэлсэн байна. Хүмүүсийн эр хүйсийг илтгэсэн бэлэг эрхтнийг тодотгон харуулсан бөгөөд тус хадан дээрх бүх дүрслэлийг сийлсэн арга барил, сэдэв зохиомж зэргээс харахад бүгд ойролцоо цаг хугацаанд бүтээгдсэн бололтой.


Зургийн сэдэв зохиомжоос үзэхэд бөөнөөрөө нийлж ан ав хийж буй байдлыг харуулсан ба дээд талд ганцаараа зогсож буй хүнийг илүү том байдлаар, багаж зэвсгийг уран нарийн сийлж гаргаснаас үзвэл магадгүй тэдний ахлагч эсвэл овгийн тэргүүлэгч хүнийг тодотгон харуулсан байж болох юм.

Малтлагын ажлыг энэхүү хадны зураг бүхий хавтан чулууны урд талын ёроол хэсэгт хийв. Малтлагын 1-р үед өнгөн хөрсийг 10 см гүнтэй малтахад ямар нэг зохион байгуулалт, эд өлгийн зүйл илрээгүй ба 20 орчим см-ын гүнээс ургаа хадны хэсгүүд малтлагын талбайн төв болон урд хэсгээр илэрч цааш үргэлжлүүлэн малтах боломжгүй болов. Улмаар малтлагын талбайн баруун хойд хэсгээс зөөлөн бор шороон хөрс үргэлжлэн гарч 30 см-ын гүнээс дээрээ дармал хээтэй шавар савны хагархай 1 ширхэг илрэв. Мөн үүний урд талаас 35 см-ын гүнээс хайрган чулуун залтас 1 ширхэг гарч, малтлагын нийт гүн 45 см болоход хадны зурагтай хавтан чулууны ёроол хэсэг бүрэн гарав. Ерөнхийдөө хавтан чулууны ёроол хэсэг гарахад газрын хөрс хатуурч, байгалийн ургаа хад талбайн ихэнх хэсгээс үргэлжлэн гарч байсан тул малтлагын ажлыг зогсоож, баримтжуулалтын ажил хийж дууссаны дараа эргүүлэн булж, нөхөн сэргээв.

Аваргын булангийн хадны зургийн дурсгалууд нь Чулуут голын хойд эрэг дагуух галт уулын гаралтай хүрмэн чулуулгаас тогтсон хадан гарцууд дээрх төвлөрч тархсан байна. Бид хадны зургийн баримтжуулалтын ажлыг хийхдээ голын эрэг дагуух 1-р дэнж дээрх зургуудыг I талбай, 2-р дэнж дээгүүрх зургуудыг II талбай хэмээн дугаарлаж бүртгэв.

I талбай нь голын голдиролд идэгдэж гарсан эрэг дагуух хүрмэн чулуун тогтоцтой мөргөцөг болон тэгш дэвсэг дээрх нийт 520 м урт, 50 м өргөнтэй талбайгаас нийт 40 гаруй хавтгайд буй хадны зургийг бүртгэв. Хадны зургийн сэдэв агуулгын хувьд харьцангуй баялаг ба ан амьтдын зураг дийлэнх хувийг эзлэнэ. Эдгээрийн дотор үхрийг дүрслэхдээ ихэвчлэн их бие хэсгийг эрээлж, хөвөөлдөн цохих аргаар зурсан байгаа нь тухайн бүс нутгийн гол онцлог болох бөгөөд он цагийн хувьд неолитын төгсгөл, хүрлийн эхэн үед дэлгэрсэн дүрслэлийн аргаар зурсан бололтой. Түүнээс гадна бугыг загварчилсан дүрс, нум сум агсаж ан хийж буй хүмүүс зэрэг хүрлийн хожуу үеийн зурагнууд нь мөн адил байна.

II талбай нь 1-р талбайн баруун хойд хэсгээр залган байрлах ба 300 м урт, 15 м өргөнтэй ба нийт 20 гаруй хавтгайд буй хадны зургийг бүртгэн баримтжуулав. Тус талбайд ихэвчлэн ан амьтдын сэдэвт зураг давамгайлах ба дээрхтэй үндсэндээ адил болно. Харин хадны зургийн тархалтын хувьд 1-р талбайгаас харьцангуй цөөн тоотой байна.



Зураг 11. Чулуут голын Аваргын булан

Чулуут голын сав дагууд амьдарч байсан эртний хүмүүсийн суурьшин амьдарч байсан ул мөрийг илрүүлэх, түүнчлэн хадны зургийг цохиж сийлэх явцад хагарч бутарч үлдсэн чулуун багаж зэвсгийн үлдэгдлийг хайх зорилгоор Аваргын буланд орших хадны зурагтай нэгэн хавтан чулууны өмнө талд бага хэмжээний газарт сорилтын малтлага хийж үзэхэд шавар савны хагархай, чулуун зэвсгийн зүйлс илэрч олдов. Тиймээс бид тус бүс нутагт археологийн судалгааг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

Хадны зургийн хайгуул хийсэн Аваргын булангийн I, II талбай нь голын голдиролд идэгдэж гарсан эрэг дагуух хүрмэн чулуун тогтоцтой мөргөцөг болон тэгш дэвсэг бөгөөд нийт 50 гаруй хавтгайд буй хадны зургийг бүртгэв. Хадны зургийн сэдэв агуулгын хувьд харьцангуй баялаг ба ан амьтдын зураг дийлэнх хувийг эзэлж байгаагийн дотор дотор үхрийг ихэвчлэн их бие хэсгийг эрээлж, хөвөөлдөн цохих аргаар зурсан байгаа нь тухайн бүс нутгийн гол онцлог болох бөгөөд он цагийн хувьд хүрлийн эхэн үед дэлгэрсэн дүрслэлийн аргаар зурсан хэмээн үзэж байна. Түүнээс гадна бугыг загварчилсан дүрс, нум сум агсаж ан хийж буй хүмүүс зэрэг хүрлийн хожуу, төмрийн түрүү үеийн зургууд нь хамгийн олон тоотой бий.

5.2. Эрдэм шинжилгээний хурал

Суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд “Төв Азийн эртний нүүдэлчдийн хадны зураг” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2022.11.11-нд Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээл дор Соёлын яамны дэмжлэгтэйгээр амжилттай зохион байгуулсан.

Хуралд Монгол Улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүх мэндчилгээ дэвшүүлж илгээлт ирүүлснийг ерөнхийлөгчийн соёл, шашны бодлогын зөвлөх Д.Бум-Очир уншиж танилцуулсан юм. Монгол улсын төдийгүй нийт хүн төрөлхтөний соёлын өвийн нэг болсон хадны зургийн дурсгалыг хадгалж хамгаалах, залуу хойч үед өвлүүлэн үлдээх, сурталчлан таниулах зорилгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн

2017 оны 7-р сарын 09-ний өдөр гаргасан “Хадны зураг, бичээсийг хамгаалах, судлах ажлыг дэмжих тухай” 181 дүгээр зарлигт хадны зураг, бичээсийн олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн- “Хадны зураг, бичээсийн чуулган”-ныг хоёр жил тутамд нэг удаа зохион байгуулж байхыг Ерөнхийлөгчийн тамгын газар, ШУА-д даалгасны дагуу энэ хурлыг тогтмол зохион байгуулж байх болно.

Хуралд Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ-ын судлаачид оролцож Төв Азийн хадны зургийн судалгааны чиглэлээр 16 илтгэл хэлэлцүүлээ.



Зураг 12. Хурлын явц



Зураг 13. Хурлын явцаас

ЗУРГАА. БҮТЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 7. Суурь судалгааны ажлын хүрээнд төлөвлөсөн болон гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл, илтгэлийн үзүүлэлт

Төлөвлөсөн ба гүйцэтгэсэн ажил	Эрдэм шинжилгээний өгүүллийн тоо	Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн тоо	Нэгэн сэдэвт зохиолын тоо
Төлөвлөсөн (Төслийн үр дүнгийн даалгавар ШуСс-2019/63 дугаар гэрээний 1-р хавсралт)	6	6	2
Гүйцэтгэсэн Төслийн хүрээнд 2019-2022 онд гүйцэтгэсэн ажлын үр дүн	8	10	2

Суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд хэвлэгдсэн бүтээлийн жагсаалт

Нэгэн сэдэв бүтээл

1. Н.Батболд, Г.Галдан. “Монголын хадны зургийн нууцаас (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” Редактор: Б.Анхбаяр. УБ., 2023 он, 183 тал.
2. Н.Батболд, Д.Содномжамц. “Чулуут - Суман голын хадны зураг” нэгэн сэдэвт бүтээлийн хэвлэлийн эхийг бэлтгэсэн.

Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

1. “Төв Азийн эртний нүүдэлчдийн хадны зураг” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн: Н.Батболд. УБ., 2022 он, 180 тал.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Н.Батболд, В.И.Молодин, Д.В.Черемисин, Ю.Н.Ненахова. *Монголын баруун хойд бүс нутагт хийсэн хадны зургийн судалгаа. //Археологийн судлал, Т. XXXVIII, Fasc. 2, УБ., 2019, тал 17-26.*
2. Ц.Төрбат. *Хэмцэгийн соёлын хадны зураг. //Археологийн судлал, Т. XXXVIII, Fasc. 1, УБ., 2019, тал 5-16.*
3. Б.Өмирбек, В.И.Молодин, Н.Батболд, Д.В.Черемисин, Ю.Н.Ненахова, Д.А.Ненахов. *Хойд хөлцөөтийн хадны зураг //Археологи, түүх, угсаатан судлалын сэтгүүл – Улаанбаатарын Их сургуулийн сэтгүүл. №15(14), УБ., 2019, тал 7-11.*
4. В.И.Молодин, Л.В.Зоткина, К.Кретэн, Д.В.Черемисин, Д.Цэвээндорж. Н.Батболд. *Палимпсест с местонахождения Цагаан салаа IV (Монгольский Алтай): относительная хронология изображений //КСИА*

(Краткие сообщение Института археологии). Вып. 260. Москва. 2020. Стр 134-150 .

5. Н.Батболд. *Төв Азийн хадны зураг ба буган хөшөө* //Археологийн судлал, Т. XXXIX, Fasc. 4, УБ., 2020, тал 39-55.
6. Н.Батболд. “Хадны зураг дахь янгирын дүрслэл” //Археологи, түүх, угсаатан судлалын сэтгүүл – Улаанбаатарын Их сургуулийн сэтгүүл. №17(16), УБ., 2021, тал 7-11.
7. В.И.Молодин, Д.В.Черемисин, Ю.Н.Ненахова, Д.А.Ненахов. Н.Батболд. *Чемурчекские антроморфы*. //Stratum plus. Archaeology and Cultural Anthropology. No.2, Санкт-Петербург, Кишинев, Одесса, Бухарест. 2022, pp.247-264.
8. Н.Батболд, Тэргүүнбаяр, Б.Анхбаяр. Шинээр олдсон эртний тэрэгний зураг. //Wenwu chungiu. 2023 (хэвлэлд).

Эрдэм шинжилгээний хурлын илтгэл

1. Н.Батболд, Ж.Гантулга, Ц.Цэлхагарав, Н.Эрдэнэ-Очир, Д.Батсүх, Ц.Төрбат. *Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт хийсэн хадны зургийн судалгаа* //Монголын археологи-2019, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. - УБ., 2019, т. 277-283.
2. Н.Батболд, В.И.Молодин, Д.В.Черемисин, Ю.А.Ненахова. *Монгол-Оросын хамтарсан хадны зураг судлах ангийн хайгуул судалгааны урьдчилсан үр дүн* - //Монголын археологи-2019, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. - УБ., 2019, т. 190-199.
3. Ц.Төрбат, Н.Батболд, Б.Өмирбек, Я.Бемманн. *Хэмцэгийн хадны зургийн судалгааны ангийн 2019 оны хээрийн шинжилгээний урьдчилсан үр дүн* //Монголын археологи-2019, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. - УБ., 2019, т. 375-382.
4. В.И.Молодин, Д.В.Черемисин, Н.Батболд, Ю.А.Ненахова. В поисках наскальных изображений на Северо-Западе Монголии. //Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий. – Новосибирс: Изд-во ИАЭТ СО РАН, 2019. – XXV. Стр. 489-497.
5. Б.Омирбек, В.И.Молодин, Н.Батболд, Д.В.Черемисин, Ю.А.Ненахова, Д.А.Ненахов. *Новые петроглифы Монголии в долине реки Хойд Холцуут*. //Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий. – Новосибирс: Изд-во ИАЭТ СО РАН, 2019. – XXV. Стр. 536-542.
6. Н.Батболд, Г.Галдан. *Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе) суурь судалгааны төсөлт ажлын хүрээнд Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт хийсэн 2020 оны хадны зургийн судалгаа* //Монголын археологи-2020, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. - УБ., 2020
7. В.И.Молодин, Д.В.Черемисин, Ю.Н.Ненахова, Н.Батболд. *Святыище чемурчекской культуры на северо-западе Монголии*. //Археологические памятники Южной Сибири и Центральной Азии: от появления первых скотоводов до эпохи сложения государственных образований: Материалы

Международной научной конференции, посвященной 85-летию доктора исторических наук Эльги Борисовны Вадецкой (1936–2018) и 90-летию доктора исторических наук Глеба Алексеевича Максименкова (1930–1986) (19–21 апреля, 2021 г., Санкт-Петербург) /отв. ред. А.В.Поляков, Н.Ю.Смирнов. — СПб.: ИИМК РАН, 2021.

8. Н.Батболд, Г.Галдан. *Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе) суурь судалгааны төслийн 2021 оны хээрийн судалгааны товч үр дүн //Монголын археологи-2021, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.* - УБ., 2021, т. 136-137
9. N.Batbold. *Explaining the Meaning of Slanting Cross Marks in the Rock Paintings //2022 Ulsan Petroglyph Museum Symposium “Rock Art as Cultural Resource: Conservation and Utilization of Cultural Heritage” – Ulsan, South Korea. September 20-25, 2022.* pp.283-291.
10. Н.Батболд, Д.Содномжамц, Б.Буян-Орших. *Хадны зургийн шинэ судалгаа (Чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе) суурь судалгааны төслийн 2022 оны хээрийн судалгааны товч үр дүн //Монголын археологи-2022, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.* - УБ., 2022, тал 30-33.

ДОЛОО. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ҮР ДҮН

2019-2022 онд “Хадны зургийн шинэ судалгаа (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” суурь судалгааны төсөл 100 хувийн гүйцэтгэлтэй амжилттай хэрэгжиж дуусаж байна.

Судалгааны ажлын үр дүнд нэгэн сэдэвт бүтээл 2, эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл 1, эрдэм шинжилгээний өгүүлэл 8, эрдэм шинжилгээний илтгэл 7, хээрийн судалгааны тайлан 4-ийг тус тус бичиж нийтлүүлэв.

Суурь судалгааны ажлын хүрээнд чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үед холбогдох хадны зургийн дурсгалуудыг тодорхой болгох, харьцуулсан судалгаа хийх чиглэлээр тодорхой ажлууд хийж гүйцэтгэсэн бөгөөд тэдгээрийг доорхи байдлаар жагсааж байна.

1. Төслийн багийн бүрэлдэхүүнд хүрлийн үеийн судалгааны чиглэлээр дагнасан судалгаа хийдэг судлаачид оролцон ажилласан нь үр дүнд чухал нөлөө үзүүлээ. Төслийн үндсэн оролцогчоор 6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Хээрийн судалгаанд жолооч 2, туслах ажилтан 5 ажилласан бол орчуулга хийхэд 2 гэсэн нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.
3. Тус төслийн хүрээнд 2019-2022 онуудад дөрвөн удаагийн хээрийн шинжилгээний ангийг Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Архангай аймгийн нутагт зохион байгуулж 50 орчим хадны зургийн дурсгалт газрыг бүртгэн баримтжуулсны 30-ыг нь шинээр илрүүлэн олж судалгааны эргэлтэд оруулж байна.
4. “Төв Азийн эртний нүүдэлчдийн хадны зураг” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, эмхтгэлийг хэвлэн гаргалаа. Уг

хуралд Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ-ын судлаачид оролцож Төв Азийн хадны зургийн судалгааны чиглэлээр 16 илтгэл хэлэлцүүлж, санал бодлоо солилцов.

5. “Монголын хадны зургийн нууцаас (чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үе)” нэгэн сэдэвт бүтээлийг хэвлэн гаргав. Энэхүү бүтээлд Монгол орны Говийн бүс нутаг дахь чулуун зэвсгийн сүүлээс хүрлийн эхэн үед холбогдох хадны зургийн дурсгалт газруудын байршлыг тогтоож, цугларсан эх хэрэглэгдэхүүнийг нэгтгэн дүгнэж, эртний нүүдэлчдийн шүтлэг бишрэл, ан авын зан үйл, ертөнцийг үзэх үзэл хадны зурагт хэрхэн туссан талаарх судалгааг хэвлүүлэв.
6. Төслийн хүрээнд “Чулуун-Суман голын хадны зураг” хэмээх нэгэн сэдэвт бүтээлийн эхийг бэлтгэв. Зохиогчоор доктор Н.Батболд, Д.Содномжамц нар ажиллав. Энэхүү зохиолд Архангай аймгийн нутаг Чулуут, Суман голын сав дахь хадны зургийн зарим дурсгалт газруудын байршил, тархалтыг нягтлан тогтоож, хадны зураг урлагийн биет олдворуудтай холбогдох эсэх, он цагийн хамаарлын талаарх судалгааг хэвлэхэд бэлэн болгосон.
7. Төслийн оролцогчид чулуун зэвсгийн үе болон хүрлийн эхэн үеийн хадны зургийн судалгаанд тулгуурласан эрдэм шинжилгээний өгүүлэл найм, илтгэл долоог дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүл, хурлын эмхэтгэлд хэвлүүлэв.
8. Суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд нийт 39,479,500 төгрөгийг захиран зарцуулав. Санхүүжилтийг 2019 онд 6,500.0 мянган төгрөг, 2020 онд 9,306.5 мянган төгрөг, 2021 онд 5,000.0 мянган төгрөг, 2022 онд 18,673,0 мянган төгрөг гэсэн байдлаар хуваарилсан. Энэхүү санхүүжилтийн дийлэнх хувийг буюу 24,348.0 мянган төгрөгийг эрдэм шинжилгээний зардалд зарцуулж үлдсэн хэсгийг гэрээт ажилтны ажлын хөлс, томилолтын зардал, орчуулгын зардал, хэвлэлийн эх бэлтгэх болон хяналтын зардалд зарцуулсан болно.
9. Бидний суурь судалгааны төсөл тодорхой хэмжээний үр дүнд хүрч, цаашдын зорилтоо тодорхойлсон хэмээн үзсэн тул “Чулуут - Суман голын хадны зураг” (2023-2025) суурь судалгааны төслийг хэрэгжүүлэн ажиллахаар шалгаруулалтанд оролцохоор бэлтгэж байна.

Тайлан бичсэн:

Сэдэвт ажлын удирдагч доктор Н.Батболд

ХАВСРАЛТ

ХЭВЛЭН НИЙТЛЭЛ